



# **БАЙГАЛЬ ОРЧНЫ**

**талаарх иргэдийн мэдлэгийг  
хэвлэл мэдээллийн  
хэрэгслийн тусламжтайгаар  
сайжруулах нь**

**судалгааны тайлан**



ДЭЛХИЙН  
БАНК



МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ  
ЯАМ



ХЭВЛЭЛИЙН  
ХҮРЭЭЛЭН

# “БАЙГАЛЬ ОРЧНЫ

талаарх иргэдийн мэдрлэгийг хэвлэл  
мэдээллийн хэрэгслийн  
тусламжтайгаар сайжруулах нь”  
судалгааны тайлан

Нидерландын Вант Улсын Засгийн  
Газрын Байгаль Орчны Итгэлийн  
Сангаас санхүүжиж, МУ-ын Байгаль  
Орчны Яаманд хэрэгжиж буй  
“Байгаль Орчны Шинэчлэл” төслийн  
хүрээнд энэхүү тайланг хэвлэв.

Улаанбаатар хот  
2006 он

# ГАРЧИГ

---

<i>НЭГ. Судалгааны аргачлал</i> .....	7
<i>ХОЁР. Өдөр тутмын сонин</i> ы байгаль орчны сэдэвт <i>мэдээллийн шинжилгээ</i> .....	9
<b><u>I. Өдөр тутмын сонинд хэвлэгдсэн байгаль орчны сэдэвт мэдээллийн тоон үзүүлэлт</u></b> .....	10
◆ Байгаль орчны талаарх мэдээллийн эзлэх хэмжээ	
◆ Байгаль орчны талаарх мэдээллийн агуулга ба хандлага	
◆ Байгаль орчны талаарх мэдээллийн субъект ба хамрах хүрээ	
◆ Байгаль орчны талаарх мэдээллийн өнцөг ба хэлбэр	
◆ Хэсгийн дүгнэлт .....	18
<b><u>II. Өдөр тутмын сонин дахь байгаль орчны сэдэвт мэдээлэл ба сэтгүүл зүйн шаардлага, хэрэгцээ</u></b> .....	20
◆ Байгаль орчны талаарх мэдээллийн бичлэгийн төрөл ба тулгуурласан баримт мэдээлэл, асуудлыг уншигчдад хүргэх аргачлал	
◆ Байгаль орчны талаарх мэдээллийн чанарын зарим үнэлгээ	
◆ Байгаль орчны талаарх мэдээллийн эх сурвалж ба мэдээллийн тэнцвэртэй байдал	
◆ Хэсгийн дүгнэлт .....	28
<b>Хавсралт</b>	
<i>ГУРАВ. Телевизийн байгаль орчны сэдэвт мэдээлэлд хийсэн шинжилгээ</i> .....	31
<b><u>I. Телевизийн мэдээлэл дэх байгаль орчны талаарх мэдээллийн тоон үзүүлэлт</u></b> .....	32
◆ Байгаль орчны талаарх мэдээллийн эзлэх хэмжээ	
◆ Байгаль орчны талаарх мэдээллийн агуулга ба хандлага	
◆ Байгаль орчны талаарх мэдээллийн субъект ба хамрах хүрээ	
◆ Байгаль орчны талаарх мэдээллийн өнцөг ба хэлбэр	
◆ Хэсгийн дүгнэлт .....	39
<b><u>II. Телевизийн байгаль орчны сэдэвт мэдээлэл ба сэтгүүл зүйн шаардлага, хэрэгцээ</u></b> .....	40
◆ Байгаль орчны талаарх мэдээллийн чанарын зарим үнэлгээ	
◆ Байгаль орчны талаарх мэдээллийн эх сурвалж ба мэдээллийн тэнцвэртэй байдал	
◆ Байгаль орчны талаарх мэдээлэл ба сэтгүүлчийн ур чадварын зарим үнэлгээ	
◆ Хэсгийн дүгнэлт .....	44
<b>Хавсралт</b>	

<i>ДӨРӨВ. FM-Радиоогийн байгаль орчны сэдэвт мэдээлэлд хийсэн шинжилгээ</i> .....	47
<b><u>I. FM-Радиоогийн мэдээлэл дэх байгаль орчны сэдэвт мэдээллийн тоон үзүүлэлт</u></b> .....	48
♦ Байгаль орчны талаарх мэдээллийн эзлэх хэмжээ	
♦ Байгаль орчны талаарх мэдээллийн агуулга ба хандлага	
♦ Байгаль орчны талаарх мэдээллийн субъект ба хамрах хүрээ	
♦ Байгаль орчны талаарх мэдээллийн өнцөг ба хэлбэр	
♦ Хэсгийн дүгнэлт .....	53
<b><u>II. FM-Радиоогийн мэдээлэл дэх байгаль орчны талаарх мэдээлэл ба сэтгүүл зүйн шаардлага, хэрэгцээ</u></b> .....	54
♦ Байгаль орчны талаарх мэдээллийн төрөл	
♦ Байгаль орчны талаарх мэдээллийн чанарын зарим үнэлгээ	
♦ Байгаль орчны талаарх мэдээллийн эх сурвалж ба мэдээллийн тэнцвэртэй байдал	
♦ Хэсгийн дүгнэлт .....	58
<b>Хавсралт</b>	
<i>ТАВ. Байгаль орчны сэдэвт олон нийтийн санал бодлын судалгааны тайлан</i> .....	61
<b><u>I. Олон нийтийн байгаль орчны талаарх мэдлэг, мэдээллийн тухайд</u></b> .....	64
♦ Байгаль орчныг хамгаалах шаардлага хэрэгцээний тухай мэдлэг	
♦ Байгаль орчноо хамгаалах талаар иргэдийн санал бодол	
♦ Байгаль орчинд тулгамдаад буй асуудлууд	
♦ Олон нийтэд байгаль орчныг хамгаалах талаар ямар мэдээлэл чухал вэ?	
<b><u>II. Олон нийтэд байгаль орчны тухай мэдлэг, мэдээлэл төлөвшихөд хэвлэл мэдээллийн хэрэгслийн оролцоо</u></b> .....	68
♦ Олон нийт байгаль орчны тухай мэдлэг, мэдээллээ ямар эх сурвалжаас авдаг вэ?	
♦ Байгаль орчныг хамгаалах иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн ач холбогдол	
♦ Хэсгийн дүгнэлт .....	71
<b>Хавсралт</b>	
♦ Байгаль орчны талаарх иргэдийн мэдлэгийг хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар сайжруулах нь төслийн нэгдсэн дүгнэлт .....	73
<b><i>ЗУРГАА. Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн болон Төрийн бус байгууллагуудад зориулсан зөвлөмж</i></b> .....	75

## СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ТАЛААР ТОВЧХОН

Дэлхийн Банкны болон Нидерландын Засгийн Газрын Байгаль Орчны Итгэлийн Сангийн дэмжлэгтэйгээр Монгол улсын Байгаль Орчны Яамны хэрэгжүүлж буй “Байгаль Орчны Шинэчлэл” төслийн хүрээнд Хэвлэлийн Хүрээлэн “Байгаль орчны талаарх иргэдийн мэдлэгийг хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар сайжруулах нь” дэд төслийг Нээлттэй Нийгэм Хүрээлэнтэй хамтран хэрэгжүүллээ. Уг төслийн хүрээнд:

1. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлж нэвтрүүлж буй байгаль орчны талаарх мэдээлэлд шинжлэх ухааны үндэслэл бүхий аргачлалд тулгуурлан агуулгын шинжилгээ болон олон нийтийн санал асуулгыг мэргэжлийн түвшинд явуулна.

2. Дээрх судалгааны дүнд тулгуурлан Хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй сэтгүүлчид, Сэтгүүл зүйн Их дээд сургуулиудын багш нарын дунд байгаль орчны талаар хэрхэн сурвалжилж олон нийтэд хүргэх, энэ талын сургалтын хөтөлбөрт хэрхэн ашиглах талаар богино хугацааны сургалтыг зохион байгуулна.

3. Төслийн үр дүнд байгаль орчны талаарх мэдлэгийн түвшин, давтамж, агуулга зэрэг тоон үзүүлэлтүүдийг гаргахын сацуу иргэдийн мэдлэгийн түвшинг тогтооно. Сургалтын үр дүнд сэтгүүлчдийн чадварт өөрчлөлт орж иргэдийн байгаль орчны талаарх мэдлэгийн хүрээг тэлэхэд жинтэй хувь нэмэр оруулна.

### Судалгааны зорилго:

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хийх агуулгын судалгаа болон олон нийтийн санал асуулгын судалгааны дүнд дараах мэдээллийг бүрдүүлэх зорилго тавьсан. Үүнд:

1. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй мэдээлэлд задлан шинжилгээ хийснээр байгаль орчны талаарх мэдээлэл нийт мэдээллийн хэдэн хувийг эзэлж буйг тодруулах. /эзлэх талбай, ач холбогдол, ямар сэдэв голлож байна, сэдвийн агуулгад юу давамгайлж байгаа, давтамж, төрөл зэргээр гаргана/

2. Байгаль орчинтой холбоотой мэдээ, мэдээлэл нь сэтгүүл зүйн шалгуур шаардлагыг хэр хангаж байгаад мэргэжлийн шинжилгээ хийхийн сацуу сэтгүүлчдийн мэргэжлийн үр чадварт зохих үнэлгээ өгөх.

3. Дээрх мэдээ, мэдээлэл нь иргэдийн ухамсар сэтгэхүйд нөлөөлөхүйц, байгаль орчны асуудалд иргэд ухамсартайгаар хандах сэтгэлгээг төлөвшүүлэхэд хэр нөлөө үзүүлж байгааг тодруулах /хэрэгцээ, шаардлагатай, сонирхолтой, ойлгомжтой, энгийн, олон нийтэд зориулсан, тэнцвэртэй, бодитой эсэх/ зэрэг болно.

4. Олон нийтийн байгаль орчны талаарх мэдлэгийн түвшин, хэрэгцээ шаардлагыг тодруулах санал асуулга

Шинжилгээний категори, мэдээллийн хуудсуудыг тус тайлангийн ерөнхий бүтцийн дагуу нэгж тайлан бүрийн ард хавсаргасан болно.

# 1. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

“Байгаль орчны талаарх иргэдийн мэдлэгийг хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар сайжруулах нь” сэдэвт төслийн хүрээнд Хэвлэлийн Хүрээлэнгийн судалгааны баг 2006 оны 1-3 сард агуулгын болон олон нийтийн санал асуулгын судалгааг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Өдөр тутмын зургаан сонин, орон даяар нэвтрүүлгээ цацаж буй зургаан телевиз, үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг нэг радио, Улаанбаатар хотод нэвтрүүлгээ цацдаг хоёр FM радиог хамруулан тэдгээрийн байгаль орчны талаарх мэдээ, мэдээлэлд агуулгын шинжилгээ хийлээ.

Судалгаанд хамрагдсан хэвлэл мэдээллийн хэрэгслийг нэрсээр жагсаавал:

1. Сонин:	2. Телевиз:	3. Радио:
<ul style="list-style-type: none"><li>○ Өнөөдөр</li><li>○ Өдрийн сонин</li><li>○ Ардын эрх</li><li>○ Улаанбаатар таймс</li><li>○ Өнөөдрийн монгол</li><li>○ Зууны мэдээ</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>○ Монголын Үндэсний телевиз</li><li>○ 25-р суваг телевиз</li><li>○ TV 5 телевиз</li><li>○ TV 9 телевиз</li><li>○ UBS телевиз</li><li>○ Ийгл телевиз</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>○ Монголын Үндэсний радио</li><li>○ Гэр бүлийн радио FM 104.5</li><li>○ Инфо FM 105.5</li></ul>

Дээрх мэдээллийн хэрэгслийг судалгааны судлагдахуун болгон сонгохдоо 1-рт гаралтын тоо болон нэвтрүүлгийн цаг, 2-рт мэдээллийн хамрах хүрээ буюу цацах хүрээ, 3-рт тухайн мэдээллийн хэрэгслийн онцлогийг харгалзсан болно.

**Тухайлбал:** улирлын давтамжийн нөлөөг харгалзан дээрх сонинуудын 2005 оны 1, 4, 7, 10-р саруудын дугаарт шинжилгээ хийсэн бол телевизид 2006 оны 1 сарын 18-25, FM-Радиод 2006 оны 2 сарын 10-17 гэсэн дурын санамсаргүй нэг долоо хоногийг сонгон ажиглалт хийсэн болно. Ингэхдээ телевиз, радиод ажиглалт хийсэн долоо хоног нь нийгмийн сенсааци дэгдсэн, цаг үеийн онцгой үйл явдлаар өрнөсөн өдрүүд байхаас аль болох зайлсхийхийг хичээсэн юм.

Улаанбаатар хот болон ойролцоох аймгуудын 500 өрхийн дунд байгаль орчны сэдэвт олон нийтийн санал асуулгын судалгааг 2006 оны нэгдүгээр сарын 16-23 ны хооронд хийж гүйцэтгэв.

## Санал асуулгын судалгааны түүвэр

*Судалгааг хоёр түвшинд явуулахдаа түүврийг дараах байдлаар сонгов.*

**1. Улаанбаатар болон Дархан-Уул, Зуунмод хотын хэмжээнд оршин сууж буй нийт айл өрх (гэр хорооллыг хамруулаад)**

Улаанбаатар хотын засаг захиргааны нэгжийн дагуу хуваагдсан 9 дүүрэг, Дархан-Уул, Зуунмод хотын нийт өрхөөс аль ч өрх судалгаанд хамрагдах магадлалтайгаар түүвэр өрхийг сонгосон. Ингэхдээ түүвэр өрхийн оршин сууж буй газар зүйн байршил нь дүүрэг тус бүрийн нийт өрхийн байршлыг төлөөлөх чадвартай байхаар сонгон авсан. Түүврийн зохист хэмжээг тодорхойлохдоо нэг өрх ойролцоогоор 330 орчим өрхийг төлөөлөхөөр бодож, дүүрэг тус бүрийн хүн ам зүйн бүтэц, хэмжээнээс шалтгаалж дараах байдлаар сонголт хийв.

<i>Дүүрэг, хотын нэр</i>	<i>Давтамж</i>	<i>Хувь</i>
Сонгино-Хайрхан	80	16,0
Баянзүрх	90	18,0
Баянгол	80	16,0
Чингэлтэй	60	12,0
Сүхбаатар	50	10,0
Хан-Уул	40	8,0
Налайх	20	4,0
Багануур	20	4,0
Дархан-Уул хот	40	8,0
Зуун мод хот	20	4,0
<b>Нийт</b>	<b>500</b>	<b>100,0</b>


*Айл өрхийг дүүрэг тус бүрээс түүвэрлэн сонгохдоо:*

Судлаачид дүүрэг хороо тус бүрийн нийт түүвэр өрхөөс санамсаргүй түүврийн аргаар судалгаанд оролцох айл өрхүүдийг сонгон авсан. Дүүрэг бүр нь засаг захиргааны жижиг нэгжүүд болох хороодод хуваагддаг бөгөөд хороо бүрийн өрхийн тоо буюу түүвэр өрх нь нийт хүн амыг төлөөлөх чадвартай байх ёстой. Энэхүү түүвэр өрхийг сонгох зарчмын дагуу судлаач бүр тогтоосон гудамжнаас судалгаанд оролцох өрхүүдийг сонгодог. Ингэхдээ судлаачид ярилцлага авах өрхийг сонгосон үйл явцыг дэлгэрэнгүй байдлаар тэмдэглэдэг.

*Ярилцлага өгөх өрхийн гишүүнийг сонгохдоо:*

Тухайн нэг өрхөөс зөвхөн нэг гишүүн санал асуулгад оролцож ярилцлага өгөхөөр сонгогдоно. 12-оос дээш насны тухайн өрхөд амьдарч буй бүх гишүүд сонгогдох боломжтой байна. Ярилцлага эхлэхээс өмнө тухайн өрхийн гишүүдээс санамсаргүй түүврийн арга буюу Киш Кридийн аргаар судалгаанд оролцох гишүүнийг сонгож ярилцлага авсан.





# ӨДӨР ТУТМЫН СОНИНД НИЙТЛЭГДСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ СЭДЭВТ МЭДЭЭЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

# 2.

"Байгаль орчны талаарх ирээдүйн мэдрэлийг хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар сайжруулах нь"



## I. Өдөр тутмын сонинд хэвлэгдсэн байгаль орчны холбогдолтой мэдээллийн тоон үзүүлэлт

### Байгаль орчны сэдэвт мэдээллийн эзлэх хэмжээ

Судалгаанд Өнөөдөр, Өдрийн сонин, Зууны мэдээ, Ардын эрх, Улаанбаатар таймс, Өнөөдрийн Монгол зэрэг зургаан сонины 1, 4, 7, 10 саруудын дугаарыг түүвэрлэн авч агуулгын шинжилгээ хийсэн. Өнөөдрийн Монгол сонины хувьд 2005 оны нэгдүгээр сард үйл ажиллагаа нь хараахан эхлээгүй байсан учраас 4, 7, 10 саруудын мэдээлэлд шинжилгээ хийсэн болно.

#### Хүснэгт 1.

#### Шинжилгээнд орсон өдөр тутмын сонины байгаль орчны /БО<sup>1/</sup> мэдээллийн давтамж ба хувь

	Өнөөдөр	Зууны мэдээ	Өдрийн сонин	Ардын эрх	Улаанбаатар таймс	Өнөөдрийн монгол	Нийт
1-р сар	35	44	16	57	40	---	192
	21,5%	28,2%	19,8%	39,0%	31,0%	---	25,5%
4-р сар	26	42	10	31	33	27	169
	16,0%	26,9%	12,3%	21,2%	25,6%	34,6%	22,4%
7-р сар	48	29	20	22	28	22	169
	29,4%	18,6%	24,7%	15,1%	21,7%	28,2%	22,4%
10-р сар	54	41	35	36	28	29	223
	33,1%	26,3%	43,2%	24,7%	21,7%	37,2%	29,6%
<b>Нийт</b>	<b>163</b>	<b>156</b>	<b>81</b>	<b>146</b>	<b>129</b>	<b>78</b>	<b>753</b>
	<b>21.6%</b>	<b>20.7%</b>	<b>10.8%</b>	<b>19.4%</b>	<b>17.1%</b>	<b>10.4%</b>	<b>100.0%</b>

---мэдээлэл байхгүй

Ажиглалтын дүнд байгаль орчны холбогдолтой нийт 753 мэдээллийг цуглууллаа. Сонинуудын хувьд байгаль орчны талаарх мэдээллийн тоон хэмжээ нь улирлын чанартайгаар өөрчлөгдөөд байдаггүй, харьцангуй тэнцвэртэй гэж хэлж болно.

Байгаль орчны холбогдолтой мэдээлэл хамгийн олон давтамжтай нийтлэгдсэн сонин нь Өнөөдөр /163/ байгаа бол түүний араас Зууны мэдээ 156, Ардын эрх 146, Улаанбаатар таймс 129, Өнөөдрийн Монгол 98 /Өнөөдрийн Монгол сонины нэгдүгээр сарын дугаар байхгүй тул сарын дундаж дугаарын тоог нэмж тавьсан болно/, Өдрийн сонин 81 удаа нийтэлжээ.

Дурын нэг долоо хоног тутам өдөр тутмын сониноор байгаль орчны сэдэвт найман мэдээлэл гардаг бөгөөд энэ нь сонин бүрээр ялгаатай. Тухайлбал Өнөөдөр сониноор долоо хоногт 10, Зууны мэдээ 9, Ардын эрх 9, Улаанбаатар таймс 8, Өнөөдрийн монгол 6, Өдрийн сонин 5 байна.

*Хүснэгт 2.*

**Өдөр тутмын сонины байгаль орчны талаарх мэдээллийн талбайн хэмжээ /статистик үзүүлэлтээр (см<sup>2</sup> -р)**

	<b>Дундаж талбай</b>	<b>Хамгийн бага талбайтай нь</b>	<b>Хамгийн их талбайтай нь</b>	<b>Нийт талбай</b>
Өнөөдөр	298,6	30	3880	48668
Зууны мэдээ	200,8	19	1598	31328
Өдрийн сонин	666,2	20	4105	53959
Ардын эрх	194,5	10	1472	28394
Улаанбаатар таймс	288,4	28	1828	37207
Өнөөдрийн монгол	248,3	33	1465	19365
Нийт	290,7	10	4105	218922

Харин байгаль орчны холбогдолтой мэдээллийг талбайгаар нь харьцуулж гаргавал Өдрийн сонин хамгийн их хэмжээтэй буюу 53959 см<sup>2</sup>, түүний дараагаар Өнөөдөр сонин 48668 см<sup>2</sup>, Улаанбаатар таймс 37207 см<sup>2</sup>, Зууны мэдээ 31328 см<sup>2</sup>, Ардын эрх 28394 см<sup>2</sup>, Өнөөдрийн монгол 19365 см<sup>2</sup> хэмжээтэй мэдээлэл нийтэлсэн байна.

Сонины байгаль орчны холбогдолтой нэг мэдээлэл нь дунджаар 290.7 см<sup>2</sup> талбайтай байна. Мэдээллийн дундаж хэмжээ нь сонин болон тухайн мэдээллийн бичлэгийн төрөл, хэлбэрээс хамаараад өөр өөр. Тухайлбал Өдрийн сонинд нийтлэгдсэн байгаль орчны холбогдолтой мэдээллийн дундаж хэмжээ 666 см<sup>2</sup> байхад Ардын эрх 194.5 см<sup>2</sup> байх жишээтэй. /Бичлэгийн төрөл хэлбэрийн тухай мэдээллийг дараагийн бүлгээс үзээрэй/

Мөн сонины байгаль орчны сэдэвт хамгийн бага талбайтай мэдээлэл нь 10 см<sup>2</sup> бол хамгийн их талбайтай нь 4105 см<sup>2</sup> талбайтай байлаа.

Байгаль орчны тухай мэдээллүүд нь харьцангуйгаар сонины эхний болон 4, 7-р нүүрүүдэд төвлөрсөн байдалтай. Гэхдээ эхний нүүрэнд голдуу богино хэмжээний мэдээ, мэдээллүүд байралдаг. Томоохон хэмжээний өгүүлэл, нийтлэл, ярилцлагууд 4, 7-р нүүрүүдэд болон түүнээс өмнөх нүүрүүдэд хуваагдаж байршжээ.

<sup>1</sup> Байгаль орчны холбогдолтой

### Хүснэгт 3.

#### Байгаль орчны талаарх мэдээлэл байршсан нүүр /Хувиар<sup>2</sup>/

	Өнөөдөр	Зууны мэдээ	Өдрийн сонин	Ардын эрх	Улаанбаатар таймс	Өнөөдрийн монгол	Нийт
1-р нүүр	25,2%	35,9%	17,3%	32,2%	47,7%	33,3%	32,6%
2-р нүүр		5,1%	4,9%		0,8%		1,7%
3-р нүүр	9,8%	7,7%	3,7%	3,4%	15,6%	5,1%	8,0%
4-р нүүр	18,4%	6,4%	2,5%	17,1%	17,2%	11,5%	13,0%
5-р нүүр	1,8%	11,5%	11,1%	19,2%	4,7%	3,8%	8,9%
6-р нүүр	3,7%	,6%		3,4%	1,6%	3,8%	2,3%
7-р нүүр	11,7%	6,4%	19,8%	14,4%	8,6%	6,4%	10,9%
8-р нүүр	3,1%	15,4%		4,8%	1,6%	14,1%	6,5%
9-р нүүр	8,0%	3,2%	2,5%	2,1%	,8%	2,6%	3,5%
10-р нүүр	3,1%	,6%		1,4%	1,6%	11,5%	2,5%
11-р нүүр	1,2%	,6%	7,4%	2,1%		3,8%	2,0%
12-р нүүр	6,1%	5,1%				3,8%	2,8%
13-р нүүр	5,5%	1,3%	13,6%				2,9%
14-р нүүр			2,5%				0,3%
15-р нүүр			6,2%				0,7%
16-р нүүр	1,2%		1,2%				0,4%
17-р нүүр			1,2%				0,1%
19-р нүүр			3,7%				0,4%
20-р нүүр	1,2%						0,3%
21-р нүүр			2,5%				0,3%
22-р нүүр							
23-р нүүр							
24-р нүүр							
Нийт	100,0%	100,0%	100,0%	100,0%	100,0%	100,0%	100,0%

Сонины нийт нүүрний эхний хагаст /Жишээ нь 10 нүүртэй сонины эхний 5 нүүрэнд/ байгаль орчны сэдэвтэй нийт мэдээллийн 77 орчим хувь нь төвлөрсөн байдаг. Жишээ нь Зууны мэдээ 89 хувь, Улаанбаатар таймс 86 хувь, Өнөөдөр 84.8 хувь, Ардын эрх 75.3 хувь, Өдрийн сонин 69.2 хувь, Өнөөдрийн Монгол сонины 57.5 хувь эхний нүүрүүдэд байрладаг байна.

<sup>1</sup> Хүснэгтийн өнгөөр ялгасан хэсгүүд нь тухайн сонины нийт нүүрийн тоог илэрхийлнэ

Хүснэгт 4.

**Өдөр тутмын сонинд байгаль орчны талаарх  
мэдээллийн эзлэх хувь**


Сонины нэр	1 нүүр мэдээллийн талбай	Сонины 1 дугаарын нүүрийн нийт тоо	1 сард гардаг дугаарын дундаж тоо	1 сарын турш гаргадаг нийт мэдээллийн талбай	4 сарын турш гаргадаг нийт мэдээллийн талбай	4 сарын турш нийтэлсэн байгаль орчны холбогдолтой нийт мэдээллийн	Байгаль орчны холбогдолтой мэдээллийн нийт мэдээлэл дунд эзлэх
Улаанбаатар таймс	1406,2	10	21	295302	1181208	37207	3,1
Өнөөдрийн монгол	1453,5	12	21	366282	1098846	19365	1,8
Зууны мэдээ	1752,4	16	25	700940	2803760	31328	1,1
Өнөөдөр	1683	20	25	841500	3366000	48668	1,4
Өдрийн сонин	1728,1	24	25	1036836	4147344	53959	1,3
Ардын эрх	1648,1	12	21	415316,2	1661265	28394	1,7

Сонины байгаль орчны холбогдолтой мэдээллийн эзлэх хувийг гаргавал 1-3 хувьтай ба дунджаар сонины нийт мэдээллийн 1.7 хувь болно.

Энэ нь сонин тус бүрээр ялгаатай. Тухайлбал Улаанбаатар таймс сонины хувьд хамгийн их буюу нийт талбайн 3.1 хувийг байгаль орчны холбогдолтой мэдээлэл эзэлдэг бол Өнөөдрийн Монгол 1.8 хувь, Ардын эрх 1.7 хувь, Өнөөдөр 1.4 хувь, Өдрийн сонин 1.3 хувь, Зууны мэдээ 1.1 хувьтай байна. /Хүснэгт 4-өөс харна уу/.

График 1.

**Өдөр тутмын сонинд нийтлэгдсэн байгаль орчны талаарх мэдээллийн эзлэх талбай**



**Байгаль орчны талаарх мэдээллийн агуулга ба хандлага**

Сонины байгаль орчинтой холбогдолтой мэдээлэлд газар хөдлөлт, далайн хар салхи, галт уул дэлбэрэлт, ган, зуд, үер, аадар бороо, мөндөр, хэт дулаарал, ой мод, зэрлэг ан амьтан ховордох, хулгайн ан, хулгайн мод, гол ус бохирдуулалт, шувууны ханиад, боом, шувууны томуу гэх мэт мал амьтны өвчлөл, нөхөн сэргээлтгүйгээр газар

тахлалт, цөлжилт, цэвэр усны хомсдол, ой хээрийн түймэр зэрэг сөрөг хандлагатай мэдээллүүд үнэмлэхүй олонх буюу 56.0 хувийг эзэлж байна. Харин мод бут тарих, хүнсний тариа ногоо суулгах, зэрлэг ан амьтны өсөлт, бойжилт, хот, ойр орчны хог хаядал, гол ус цэвэрлэлт, байгалийн баялаг, нөөц бололцоог үр ашигтай, зүй зохистойгоор ашиглалт, байгалийн эсрэг зүй бус үйлдэлтэй тэмцэж буй хувь хүн, албан байгууллага, төр засгийн тэмцэл / агаарын бохирдолыг бууруулах шахмал түлш, юнигаз, ногоон хэрэм гм төслийн арга хэмжээ/ зэрэг эерэг хандлагатай мэдээлэл 23.8 хувь, мөн эерэг болон сөрөг аль алийг нь агуулсан төвийг сахисан мэдээлэл 20.2 хувийг эзэлж байлаа.

Агуулгын талаасаа Байгалийн гамшигт үзэгдлийн тухай мэдээлэл харьцангуй их буюу 30.1 хувьтай байгаа бол удаах байруудад Ургамал, ан амьтан /24.7 хувь/, Мод, ойн хомсдол /8.0 хувь/, Ашигт малтмал, түүний орд газар /6.9 хувь/, Цаг агаарын өөрчлөлт /5.4 хувь/ зэрэг багтаж байна. /Дэлгэрэнгүйг Хүснэгт 5-аас үзнэ үү/

**Хүснэгт 5.**

**Байгаль орчны талаарх мэдээллийн  
агуулга ба хандлага**

Агуулга	Хандлага	Эерэг	Төвийг сахисан	Сөрөг	Нийт
1	Байгалийн гамшиг	37	28	162	227
		16,3%	12,3%	71,4%	30,1%
2	Ургамал ан амьтан	54	35	87	176
		30,7%	19,9%	49,4%	24,7%
3	Мод, ойн хомсдол	19	8	33	60
		31,7%	13,3%	55,0%	8,0%
4	Ашигт малтмал, орд газар	6	22	24	52
		11,5%	42,3%	46,2%	6,9%
5	Цаг агаарын өөрчлөлт	4	10	27	41
		9,8%	24,4%	65,9%	5,4%
6	Бусад	16	4	16	36
		44,4%	11,1%	44,4%	4,9%
7	Агаарын бохирдол	9	9	13	31
		29,0%	29,0%	41,9%	4,1%
8	Байгаль хамгаалал	14	6	6	26
		53,8%	23,1%	23,1%	3,5%
9	Хог хаягдал	8	9	9	26
		30,8%	34,6%	34,6%	3,5%
10	Гол ус, усны бохирдол	2	7	15	24
		8,3%	29,2%	62,5%	3,3%
11	Улсын тусгай хамгаалалтын газар	2	5	6	13
		15,4%	38,5%	46,2%	1,7%
12	Газар хөрс, хөрсний бохирдол	4	1	6	11
		36,4%	9,1%	54,5%	1,5%
13	Хорт бодис		4	5	9
			44,4%	55,6%	1,2%
14	Озоны давхарга		1	4	5
			20,0%	80,0%	,7%
15	Цөлжилт, хөрсний элэгдэл	1	1	2	4
		25,0%	25,0%	50,0%	,5%
Нийт		176	150	415	741
		23,8%	20,2%	56,0%	100,0%

## Байгаль орчны талаарх мэдээллийн субъект ба хамрах хүрээ

Сонины байгаль орчны тухай мэдээллийн дийлэнх хэсэг нь нийт олон нийтэд хандсан /84.2 хувь/ байгаа бол тодорхой нэг хувь хүнд хандсан 0.3 хувь, нийгмийн хэсэг бүлэгт, тухайлбал хүүхэд залуучуудад хандсан 0.7 хувь, улс төрчид удирдах түвшнийхэнд хандсан 12.5 хувь, Бизнес, аж ахуйн нэгж, хувийн хэвшилд хандсан нь 2.4 хувийг эзэлсэн байна.

Тодорхой нэг хувь хүн болон хүүхэд залуучуудад хандсан байгаль орчны тухай мэдээлэл нь харьцангуйгаар ургамал ан амьтан, байгаль хамгааллын сэдэвтэй байгаа бол улс төрчид, нийгмийн удирдах түвшнийхэнд хандсан мэдээлэл нь ашигт малтмал, түүний орд газар, ой мод, модны хомсдолыг тойрсон асуудлуудыг хөндсөн байна. Бизнес, аж ахуйн нэгж байгууллагуудад хандсан мэдээлэл нь агаарын бохирдол, эерэг утгаараа бол түүнийг бууруулахад чиглэгдсэн шахмал түлшний үйлдвэрлэл, тэрчлэн ашигт малтмал, сөрөг талаасаа бол орд газруудыг зүй зохисгүйгээр ашиглалт зэрэг эмзэг асуудлуудад төвлөрч, нийт олон нийтэд хандсан мэдээлэл нь ихэвчлэн байгалийн гамшигт

үзэгдэл, түүнээс урьдчилан сэргийлэх, болон түүнтэй холбогдсон бусад мэдээллүүд мөн ургамал, ан амьтны тухай сэдвүүдийг хамарч байна.

Сонины байгаль орчны талаарх мэдээлэл нь газар зүйн хувьд дотоодын чанартай 66.9 хувь /Үүнээс аймаг, хот, сум, дүүрэг гэх мэт тодорхой нутаг орны чанартай 31.5 хувь, бүс нутгийн чанартай 7.4 хувь, нийт улсын чанартай нь 27.9 хувь/, гадаадын болон дэлхий нийтийн чанартай 33.1 хувьтай байна.

Дотоодын чанартай мэдээллүүд нь харьцангуйгаар ашигт малтмал, түүний орд газар, ургамал ан амьтантай холбоотой байгаа бол, бүс нутгийн хэмжээний мэдээлэл нь цаг агаарын өөрчлөлттэй, харин нутаг орны хэмжээний мэдээлэл нь ой мод, модны хомсдол, хог хаягдал, агаарын бохирдолтой холбоотой байна. Гадаадын тодорхой нэг улс орон болон дэлхий нийтийн чанартай мэдээллүүд нь байгалийн гамшигт үзэгдэл, ан амьтантай холбоотой аж.

## Байгаль орчны талаарх мэдээллийн өнцөг ба хэлбэр

Аливаа мэдээллийн хэлбэрээс түүний хэрэглэгчдэд өгөх үр өгөөж ихээхэн хамаарч байдаг. Энэ үүднээс байгаль орчны холбогдолтой мэдээллийг хэлбэрээр нь үндсэн дөрвөн бүлэгт хувааж шинжилсэн юм. Үр дүнгээс харвал, байгаль орчны холбогдолтой мэдээллийн ойролцоогоор гуравны нэг нь /29.8 хувь/

асуудал хөндсөн шинжтэй бол 28.8 хувь нь энгийн мэдээллийн, 23.8 хувь нь сургалт, сурталчилгаа сэрэмжлүүлэг хэлбэрийн, 17.6 хувь нь танин мэдэхүйн хэлбэртэй байна.

Сургалт сурталчилгаа, сэрэмжлүүлгийн хэлбэртэй мэдээллийн үнэмлэхүй хэсэг нь сэрэмжлүүлэг, сурталчилгааны чанартай бол *иргэдэд байгаль орчны талаарх мэдлэг мэдээлэл олгох зорилготой бөгөөд тэдгээр нь хувь хүний өдөр тутмын амьдралд хэрэглэгдэх боломжийг агуулсан хэсэг нь хангалтгүй хэмжээтэй аж.* Энэ нь дээрх сургалт, сурталчилгаа сэрэмжлүүлгийн




шинжтэй мэдээллийн дөнгөж 8.8 хувийг эзэлж байна.

Мөн асуудал хөндсөн мэдээлэл нь дунджаар 456 см<sup>2</sup> хэмжээтэй бөгөөд байгаль орчны сэдэвт мэдээллийн нийт талбайн 46.8 хувийг эзэлдэг. Танин мэдэхүйн хэлбэртэй мэдээлэл 19 хувийг

эзэлж 313.8 см<sup>2</sup> талбайтай, сургалт, сурталчилгааны хэлбэртэй мэдээлэл 20.4 хувийг эзэлж 248.3 см<sup>2</sup> талбайтай, энгийн цаг үеийн мэдээлэл нь 13.8 хувь бөгөөд дунджаар 139.7 см<sup>2</sup> талбайг эзэлж байна.

**График 2.**

**Сонины байгаль орчны тухай мэдээллийн зорилго /хувь, хэмжээгээр/**



Байгаль орчны сэдвийг хөндсөн өнцгөөр нь ангилж үзвэл эдийн засгийн 15.1 хувь, улс төрийн 5.1 хувь, социаль буюу нийгмийн 40.5 хувь, оюун санаа 39.3 хувьтай байна. Тухайлбал ашигт малтмал, түүнийг ашиглахтай холбоотой асуудалд сэтгүүлчид илүү улс төрийн талаас нь хандаж, байгалийн гамшигт үзэгдэлд юуны өмнө хүний амь нас, эрүүл мэндэд хүргэсэн хор хохирол /Социаль буюу нийгмийн өнцгөөс нь/, түүнчлэн төр засаг болон олон нийтэд учруулсан мөнгө, эд материалын гарлага талаас нь

/Эдийн засгийн өнцгөөс нь/, харин ургамал, зэрлэг ан амьтны асуудлуудад байгаль хамгаалал, түүнтэй холбогдох хүний ёс суртахууны өнцгөөс нь /оюун санаа/ илүү ханджээ.

## ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

- Өдөр тутмын сонины байгаль орчны сэдэвт мэдээллийн тоон хэмжээ нь улирлын чанартайгаар өөрчлөгдөөд байдаггүй. Харин агуулгын хувьд тодорхой өөрчлөлт ажиглагддаг.

- Сонинд нийтлэгдсэн нийт мэдээллийн дунджаар 1.7 хувь нь байгаль орчны холбогдолтой мэдээлэл байв.

- Байгаль орчны холбогдолтой мэдээллийг талбайгаар нь харьцуулж гаргавал нэг сонин сард дунджаар 9518 см<sup>2</sup> талбайд буюу дунджаар А2-ын зургаан нүүр байгаль орчны тухай мэдээлэл гаргадаг бөгөөд нэг мэдээллийн дундаж талбай 290.73 см<sup>2</sup> буюу А2-ын наймны нэг хэмжээтэй аж.

- Өдөр тутмын сониноор 7 хоног тутамд байгаль орчны сэдэвт найман мэдээлэл гардаг бөгөөд энэ нь сонин бүрээр ялгаатай. Тухайлбал Өнөөдөр сониноор 7 хоногт 10, Зууны мэдээ 9, Ардын эрх 9, Улаанбаатар таймс 8, Өнөөдрийн монгол 6, Өдрийн сонин 5 байна.

- Байгаль орчны тухай мэдээллүүдийн дийлэнх нь сонины эхний болон 4, 7-р нүүрүүдэд төвлөрсөн байдалтай. Гэхдээ эхний нүүрэнд богино

голдуу богино хэмжээний мэдээ мэдээллүүд байралдаг бөгөөд тэдгээрийн дийлэнх нь байгалийн гамшигт үзэгдлийн талаархи сөрөг буюу сенсаацитай мэдээлэл байдаг аж. Томоохон хэмжээний өгүүлэл, нийтлэл, ярилцлагууд 4, 7-р нүүрүүдэд болон түүнээс өмнөх нүүрүүдэд хуваагдаж байршжээ. Ерөнхийдөө сонины эхний хагас нүүрүүдэд /Жишээ нь 10 нүүртэй сонины эхний 5 нүүрэнд/ байгаль орчны сэдэвтэй нийт мэдээллийн 77 орчим хувь нь төвлөрсөн байдаг. Жишээ нь Зууны мэдээ 89 хувь, Улаанбаатар таймс 86 хувь, Өнөөдөр 84.8 хувь, Ардын эрх 75.3 хувь, Өдрийн сонин 69.2 хувь, Өнөөдрийн монгол сонины 57.5 хувь эхний хагас нүүрүүдэд бичигдсэн байна.

- Сонины байгаль орчны тухай мэдээллийн дийлэнх хэсэг нь нийт олон нийтэд хандаж /84.2 хувь/ байгаа нь асуудалд хандах зорилтот бүлэг нь тодорхой бус байна. Нийт олон нийтэд гэхээсээ илүүтэй нийгмийн тодорхой нэг бүлэг тухайлбал, хүүхэд залуучуудад, бизнесийн байгууллага аж ахуйн нэгжид, нийгмийн удирдах түвшнийхэнд гэх зэргээр хандвал илүү ач холбогдолтой байх бололцоотой. Тэдгээр зорилтот бүлгийн уг мэдээлэлд өгөх ач холбогдол өсөх хандлагатай юм.

- Асуудалд хандах хандлага нь үнэмлэхүй утгаараа /56.0 хувь/ сөрөг байсан бол 23.8 хувь нь эерэг, 20.2 хувь нь төвийг сахисан шинжтэй байлаа.

- Агуулгын талаасаа байгалийн гамшигт үзэгдлийн тухай мэдээлэл харьцангуй их буюу 30.1 хувьтай байгаа бол түүний араас эхний тавд ургамал, ан амьтан /24.7 хувь/, Мод, ойн хомсдол /8.0 хувь/, Ашигт малтмал, түүний орд газар /6.9 хувь/, Цаг агаарын өөрчлөлт /5.4 хувь/ зэрэг багтаж байна.

- Сонины байгаль орчны сэдэвт мэдээлэл нь газар зүйн хамрах хүрээгээр дотоодын чанартай 66.9 хувь, гадаадын болон дэлхий нийтийн чанартай 33.1 хувь мэдээллийг багтааж байна.

- Байгаль орчны холбогдолтой мэдээллийн гуравны нэг нь /29.8 хувь/ асуудал хөндсөн, 28.8 хувь нь энгийн мэдээллийн, 23.8 хувь нь сургалт, сурталчилгаа сэрэмжийн, 17.6 хувь нь танин мэдэхүйн хэлбэртэй байдаг ажээ. Сургалт сурталчилгаа, сэрэмжлүүлгийн хэлбэртэй мэдээллийн дийлэнх хэсэг нь сэрэмжлүүлэг, сурталчилгааны чанартай байгаа бол иргэдэд байгаль орчны талаарх мэдлэг мэдээлэл олгох зорилготой бөгөөд тэдгээр нь хувь хүний өдөр тутмын амьдралд хэрэглэх боломжийг агуулсан хэсэг нь хангалтгүй хэмжээтэй буюу дээрх сургалт, сурталчилгаа сэрэмжлүүлгийн мэдээллийн дөнгөж 8.8 хувийг эзэлж байна.

- Байгаль орчны сэдвийг хөндсөн өнцгөөр нь ангилж үзвэл, эдийн засгийн 15.1 хувь, улс төрийн 5.1, социаль буюу нийгмийн 40.5 хувь, оюун санаа 39.3 хувьтай байх бөгөөд тэдгээрийг агуулгаар нь харьцуулбал ашигт малтмал, түүнийг ашиглахтай холбоотой асуудалд сэтгүүлчид илүү улс төрийн талаас нь, байгалийн гамшигт үзэгдэлд юуны өмнө хүний амь нас, эрүүл мэндэд хүргэсэн хор хохирол /Социаль буюу нийгмийн өнцгөөс/, түүнчлэн төр засаг болон олон нийтэд учруулсан мөнгө, эд материалын

гарлага талаас нь /Эдийн засгийн өнцгөөс/, харин ургамал, зэрлэг ан амьтан чиглэлийн асуудлуудад байгаль хамгаалал, түүнтэй холбогдох хүний ёс суртахууны өнцгөөс нь /оюун санаа/ түлхүү авч үзжээ.

Өдөр тутмын сонины нийт талбайд ажиглалт хийхэд байгаль орчны талаарх мэдээллүүдийг хэсэг бусаг энд тэнд замбараагүй байдлаар байрласан нь ажиглагдлаа. Иймд тодорхой нэг сэдвийн мэдээллийг тогтмол нэг нүүрэнд гаргаж, өөрийн булантай байвал тогтмол уншигчидтай болж, уншигчдад хүрэх ач холбогдол өсөх талтай.

**II. ӨДӨР ТУТМЫН СОНИН ДАХЬ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХОЛБОГДОЛТОЙ  
МЭДЭЭЛЭЛ БА СЭТГҮҮЛ ЗҮЙН ШААРДЛАГА, ХЭРЭГЦЭЭ**

**Байгаль орчны талаарх мэдээллийн  
бичлэгийн төрөл, тулгуурласан баримт, асуудлыг уншигчдад  
хүргэх аргачлал**

Сонины уншигч хэрэглэгчдэд байгаль орчны талаарх мэдээлэл, ялангуяа байгаль, хүрээлэн буй орчинтойгоо зөв зохистой харьцах, хандах талаар мэдлэг олгох, төлөвшүүлэх утгаараа бичлэгийн төрөл, тулгуурласан баримт, агуулга санаагаа уншигчдад хүргэх аргачлал зэрэг нь багагүй ач холбогдолтой.

*Хүснэгт 6.*

**Өдөр тутмын сонин дахь байгаль орчны сэдэвт  
мэдээллийн бичлэгийн төрөл ба тулгуурласан  
баримт. /Давтамж, хувиар/**

Тулгуур Бичлэгийн төрөл	Статистик тоо баримтад тулгуурласан	Судалгааны материалд тулгуурласан	Ишлэл ярианд тулгуурласан	Ажиглалтанд тулгуурласан	Бусад	Нийт
Мэдээ	49	92	14	260	49	464
	10,6%	19,8%	3,0%	56,0%	10,6%	61,6%
Сурвалжлага	7	8	8	22	1	46
	15,2%	17,4%	17,4%	47,8%	2,2%	6,1%
Нийтлэл/ Өгүүлэл	13	66	13	39	1	132
	9,8%	50,0%	9,8%	29,5%	,8%	17,5
Ярилцлага	7	17	18	11		53
	13,2%	32,1%	34,0%	20,8%		7,0%
Захидал санал		7	1	1	1	10
		70,0%	10,0%	10,0%	10,0%	1,3 %
Хөрөг /зураг/						0,7%
Тэмдэглэл	1	5	6	9		21
	4,8%	23,8%	28,6%	42,9%		2,8%
Редакцийн өгүүлэл			1			1
			100,0%			0,1%
Хэлэлцүүлэг		2	8			10
		20,0%	80,0%			1,3%
Эрэн сурвалжилсан өгүүлэл	2	2	1	5	1	11
	18,2%	18,2%	9,1%	45,5%	9,1%	1,5%
Нийт	79	199	70	347	53	748
	10,6%	26,6%	9,4%	46,4%	7,1%	100,0 %

Дээрх хүснэгтээс харвал, судалгаа болон статистик тоо баримтад тулгуурласан байгаль орчны сэдэвт мэдээллүүдийг баримтжуулалт сайтай хэмээн үзвэл, ийм төрлийн мэдээлэл 37.2 хувийг эзэлж байна. Ихэвчлэн нийтлэл /өгүүлэл, эрэн сурвалжилсан өгүүлэл гм/, сурвалжлага, ярилцлага зэрэг нь энэ төрлийн баримтуудад түшиглэжээ. Харин мэдээний хувьд статистик болон судалгааны баримт материалаасаа илүүтэйгээр тухайн цаг үеийн мэдээлэл, ажиглалтанд тулгуурласан байх нь олонтой.

Бичлэгийн төрөл зүйлийн хувьд эзлэх талбайн хэмжээг тооцож үзвэл хамгийн бага нь 119 см<sup>2</sup> талбайтай “Мэдээ” нь нийт мэдээллийн 61.6 хувийг эзэлсэн бол 799.5 см<sup>2</sup> талбайтай “Хэлэлцүүлэг” 1.3 хувь байна. Энэ мэтчилэн их талбайг хамарсан бичлэгийн төрлүүд нь давтамжаараа маш бага хувийг эзэлдэг аж. Тухайлбал мэдээ нийт талбайн 25.2 хувийг эзэлж байгаа бол нийтлэл /өгүүлэл/ 36.3 хувь, ярилцлага 15.0 хувь, сурвалжлага 8.9 хувь нь байна. /Дэлгэрэнгүйг Хүснэгт 7-с үзнэ үү./

### Хүснэгт 7.

#### Байгаль орчны сэдэвт мэдээллийн бичлэгийн төрлийг талбайгаар нь харьцуулбал / см<sup>2</sup> болон хувиар/

	Дундаж талбай	Нийт талбай	Нийт талбайд эзлэх хувь	Нийт давтамжид эзлэх хувь
Мэдээ	119,08	55254	25,2%	61,6%
Нийтлэл/ Өгүүлэл	601,92	79453	36,3%	17,5%
Ярилцлага	617,78	32742	15,0%	7,0%
Сурвалжлага	421,59	19393	8,9%	6,1%
Тэмдэглэл	558,24	11723	5,4%	2,8%
Эрэн сурвалжилсан өгүүлэл	650,91	7160	3,3%	1,5%
Захидал санал	239,10	2391	1,1%	1,3%
Хэлэлцүүлэг	799,50	7995	3,7%	1,3%
Хөрөг	532,60	2663	1,2%	,7%
Редакцийн өгүүлэл	147,00	147	,1%	,1%
<b>Нийт</b>	<b>290,73</b>	<b>218922</b>	<b>100,0%</b>	<b>100,0%</b>

**Хүснэгт 8.**

**Байгаль орчны сэдэвт мэдээллийн бичлэгийн төрлийг  
өдөр тутмын сониноор гаргавал / Хувиар**

	Өнөөдөр		Зууны мэдээ		Өдрийн сонин		Ардын эрх		УБ-таймс		Өнөөдрийн монгол	
	НБХ <sup>1</sup>	ДБХ <sup>2</sup>	НБХ	ДБХ	НБХ	ДБХ	НБХ	ДБХ	НБХ	ДБХ	НБХ	ДБХ
Мэдээ	17.6	55.8	33.4	75.6	18.2	29.6	41.9	69.2	29.3	66.7	18.6	56.4
Нийтлэл/ Өгүүлэл	60.5	27.6	14.6	3.8	34.8	27.2	27.6	19.2	37.9	14.0	24.4	16.7
Ярилцлага	12.5	6.7	30.8	9.6	3.0	1.2	21.7	6.8	11,	6.2	26.6	10,3
Сурвалж- лага	1.5	2.5	13,5	7,7%	13,5	18,5			10,0	6,2	17,5	9,0
Тэмдэглэл					16,1	11,1	3,4	1,4	3,7	4,7	3,5	5,1
Эрэн сурвалжил- сан өгүүлэл			6,4	2,6			3,3	2,1	6,4	1,6	9,5	2,6
Захидал санал	3,6	4,9	1,3	0,6	0,4	1,2						
Хэлэлцүү- лэг					14,0	11,1	1,6	0,7				
Хөрөг	4,3	2,5							1,6	0,8		

Байгаль орчны тухай мэдээлэл нь өөр бусад төрлийн тухайлбал авилгал, хээл хахууль, улс төр, засаглал зэрэгтэй холбоотой мэдээллүүдтэй харьцуулбал илүү нээлттэй учраас уншигчад шууд хэлбэрээр хүрэх нь илүү аж. Судалгааны дүнгээс үзвэл нийт мэдээллийн 93.4 хувь нь шууд, 6.6 хувь нь дам байдлаар хүрчээ. Дам хэлбэрээр хүрсэн мэдээллүүд дундаа байгалийн баялаг, ашигт малтмалын орд газаруудтай холбоотой асуудлууд голлож байлаа.

<sup>1</sup> Байгаль орчны сэдэвт мэдээллийн нийт талбайн нийлбэрээс бодсон хувь


<sup>2</sup> Байгаль орчны сэдэвт мэдээллийн нийт давтамжаас бодсон хувь

## Байгаль орчны талаарх мэдээллийн эх сурвалж ба мэдээллийн тэнцвэртэй байдал

Өдөр тутмын сонины байгаль орчны тухай мэдээллийг хүн ба байгалийн шүтэлцээ харилцан холбоо талаас нь шинжилж үзлээ. Шинжилгээний үр дүнд байгаль дэлхийгээс хүмүүст хүргэсэн мэдээлэл 43.5 хувь буюу хамгийн их хэмжээтэй байв. /Дэлгэрэнгүйг График 3-с харна уу/

**График 3.**

**Байгаль орчны сэдэвт мэдээллийн хүн ба байгаль дэлхийн шүтэлцээ холбооны талаарх мэдээллийн тэнцвэртэй байдал /Хувиар/**



Түүнчлэн байгаль орчны талаарх мэдээллийн эх сурвалж тодорхой эсэхийг шалгаж үзэхэд нийт мэдээллийн 79.3 хувь нь ил /эх сурвалжийн нэрийг дурьдаж баталгаажуулсан/, 11.7 хувь нь далд /эх сурвалжаа ерөнхийд нь тодруулж нэргүй иш татсан/, 3.3 хувь нь далдын далд /сэтгүүлч тухайн мэдээллийг нэвтрүүлэгт ашигласан боловч ямар эх сурвалжаас авсанаа хэлэхгүй байх, тухайлбал: албан ёсны эх сурвалжаар бол, нэгэн эх сурвалжийн мэдээлсэнээр гм/, 5.7 хувь нь тодорхойгүй /эх

сурвалжаас авсан эсэх нь огт тодорхойгүй/ байв. Сэтгүүл зүйн бичлэгийн төрлөөр авч үзвэл нэлээд том хэмжээний талбай эзлэх нийтлэл, өгүүллүүд нь эх сурвалж ашиглалт тал дээр хангалтгүй байсныг дурьдах хэрэгтэй.



## Байгаль орчны талаарх мэдээллийн чанарын зарим үнэлгээ

Аль ч сэдвийн, ямар ч зорилготой мэдээлэл байсан түүний чанар хангалтгүй бол хичнээн их хэмжээний талбайд, хичнээн олон давтамжтайгаар нийтэлсэн ч үр өгөөж бага байх нь ойлгомжтой.

Өдөр тутмын сонинуудад нийтлэгдсэн мэдээллийн чанар, тэр дундаа байгаль орчинтой холбоотой мэдээлэл, түүний цаана байх сэтгүүлчийн ур чадварыг тодорхой шалгуураар дүгнэж үнэлгээ өгөхийг хичээлээ.

Бид өдөр тутмын сонины байгаль орчинтой холбоотой мэдээллийн чанарыг тус бүр 12 эмпирик үзүүлэлтээр шүүн тунгаасан болно. Юуны өмнө хүчин зүйлийн шинжилгээ (Factor analyze)-ний үр дүнд нийт хувьсагчаа 3 бүлэг хүчин зүйлд нэгтгэн гаргавал:

1-р бүлэг хүчин зүйлд: мэдээллийн найруулга, үгийн сонголт, мэдээллийн шийдэл, ойлгомжгүй сунжруу өгүүлбэрээс зайлсхийсэн байдал, мэдээллийн шуурхай байдал, мэдээллийн хэмжээ агуулгатайгаа тохирсон эсэх, залхмаар урт сунжруу ишлэлээс зайлсхийсэн эсэх, энгийн ойлгомжтой эсэх зэрэг хувьсагчид орсон


2-р бүлэг хүчин зүйлд: мэдээлэл уншигчдын сонирхлыг татахуйц байгаа эсэх, мэдээллийн үр өгөөж зэрэг хувьсагчид,

3-р бүлэг хүчин зүйлд: мэдээлэл тодорхой баримтад тулгуурласан эсэх, техникийн тайлбаргүй нэр томъёо ашигласан эсэх зэрэг хувьсагчид орсон.

Дээрх бүлгүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлвэл эхний хүчин зүйл нь өнөөгийн сонинуудын байгаль орчны талаарх мэдээллийн чанарын боломжийн талыг илэрхийлсэн, 3-р бүлэг хүчин зүйл нь дундаж үзүүлэлтийг, харин 2-р бүлэг хүчин зүйл нь нэлээд анхаарууштай талыг харуулж байна хэмээн ойлгож болно. Өөрөөр хэлбэл сонинууд хүмүүст байгаль орчны тухай зөв, зүйтэй мэдлэг мэдээллийг олгохыг зорилгоо болговол нэн түрүүнд мэдээллээ сонирхолтойн дээр үр өгөөжтэй байлгах талын асуудлыг анхаарах хэрэгтэй байна. /График 4/ Үнэлгээний эерэг утгаар нь харьцуулан гаргасан/ болон Хүснэгт 9-с дэлгэрүүлж харна уу/

**График 4.**

**Байгаль орчны талаарх сонины мэдээллийн чанарын зарим үзүүлэлтүүд /Эерэг утгаар/**



## Хүснэгт 9.

**Өдөр тутмын сонины байгаль орчны сэдэвт мэдээллийн  
бичлэгийн төрөл ба тэдгээрийн чанарын зарим үзүүлэлтүүд**  
*/Эрэг, сөрөг утгын харьцуулалт  
/ хураангуйлсан хэлбэрээр/*

Мэдээллийн хэлбэр	Эрэг утга илүү авсан категори	Эзлэх хувь	Сөрөг утга илүү авсан категори	Эзлэх хувь
Мэдээ	Агуулга энгийн ойлгомжтой байсан / хэмжээ агуулгатайгаа тохирсон	98.5	Мэдээлэл үр өгөөж багатай байсан	27.1
Сурвалжлага	Агуулга ойлгомжтой /тодорхой баримтад тулгуурласан	93.4	Хүмүүсийн анхаарлыг татахуйц сонирхолтой байгаагүй	30.4
Нийтлэл	Агуулга хэмжээтэйгээ тохирсон/ тодорхой баримтад тулгуурласан	96.2	Мэдээлэл үр өгөөж бага байсан	11.8
Ярилцлага	Шийдэл, үгийн сонголт, ишлэлээс зайлсхийсэн, ойлгомжтой байсан	100.0	Хүмүүсийн анхаарлыг татахуйц сонирхолтой байгаагүй	21.6
Тэмдэглэл	Энгийн ойлгомжтой / тодорхой баримтад тулгуурласан	95.0	Мэдээллийн шийдэл оновчтой байгаагүй	15.0
Хэлэлцүүлэг	Үгийн сонголт сайтай, сунжруу өгүүлбэр, техникийн нэр томъёо ашиглаагүй	88.9	Мэдээлэл үр өгөөж бага байсан	60.0
Эрэн сурвалжилсан өгүүлэл	Үр өгөөжтэй, шийдэл оновчтой, агуулга хэмжээ тохирсон, цаг үедээ нийцсэн, баримтад тулгуурласан	100.0	Найруулга хангалттай байгаагүй	11.1

Дээрх хүснэгтээс харвал сэтгүүл зүйн бичлэгийн төрлүүдээс мэдээ, хэлэлцүүлэг нь ойлгомжтой энгийн давуу талтай ч мэдээллийн ач холбогдол үр өгөөжийн хувьд харьцангуй тааруу үнэлгээ авчээ.

Өдөр тутмын сонины байгаль орчны талаарх нийт мэдээллийн 61.6 хувийг зөвхөн мэдээ эзэлж байгааг анхаарч уншигчдад хүрэх ач холбогдолтой бичлэгийн хэлбэрийг сонгож байх нь зүйтэй болов уу.

Эрэг үзүүлэлтээс харвал эрэн сурвалжилсан өгүүлэл болон нийтлэлийн агуулга хэмжээ тохирсоны сацуу тодорхой баримтад тулгуурласан байдгаараа давуу аж. Харин ярилцлага, сурвалжлага зэрэг нь хүмүүсийн анхаарлыг татахуйц сонирхолтой байж чаддаггүй байна.

**Хүснэгт 10.**

**Өдөр тутмын сонины байгаль орчны сэдэвт мэдээллийн хэлбэр ба тэдгээрийн чанарын зарим үзүүлэлтүүд**  
*/Эерэг утгын харьцуулалтаар/*

Ч-Үзүүлэлт Мэдээллийн хэлбэр	Мэдээллийн агуулга энгийн ойлгомжтой	Мэдээлэл хүмүүсийн анхаарлыг татахуйц сонирхолтой	Мэдээлэл үр өгөөжтэй	Мэдээллийн шийдэл оновчтой	Мэдээллийн хэмжээ агуулгатайгаа тохирсон	Мэдээллийн найруулга хангалттай байсан
Энгийн мэдээллийн хэлбэртэй	98,6 <sup>1</sup>	59,6	50,3	93,6	97,8	97,8
Асуудал хөндсөн	94,6	73,6	82,6	89,2	95,7	90,1
Сургалт, сурталчилгаа, сэрэмжийн хэлбэртэй	97,2	77,3	89,1	95,8	97,5	95,8
Танин мэдэхүйн хэлбэртэй	96,1	92,2	88,1	94,5	96,3	95,0
Ч-Үзүүлэлт Мэдээллийн хэлбэр	Мэдээлэлд хэрэглэсэн үгийн сонголт оновчтой байсан	Ойлгоход хэцүү сунжруу өгүүлбэрээс зайлс хийсэн	Техникийн тайлбаргүй нэр томъёо ашиглаагүй	Залхмаар урт сунжруу ишлэлээс зайлсхийсэн байдалтай	Тодорхой баримтад тулгуурласан	Цаг үедээ тохирсон шуурхай
Энгийн мэдээллийн зорилготой	97,7	97,7	84,2	96,9	91,1	98,5
Асуудал хөндсөн	91,8	94,7	89,4	93,7	91,4	93,8
Сургалт, сурталчилгаа, сэрэмжийн зорилготой	96,9	95,7	75,2	97,5	97,1	95,4
Танин мэдэхүйн зорилготой	95,7	92,6	89,3	95,4	96,8	93,5

Мэдээллийн зорилгын талаасаа энгийн мэдээллүүд нь үр өгөөж багатай гэсэн үнэлгээ авсан бол сургалт болон танин мэдэхүйн зорилготой мэдээллүүд нь уншигчдад илүүтэй хүрч тэдний байгаль орчны талаарх зохистой мэдлэгт нөлөөлөх магадлалтай болох нь судалгааны дүнгээс харагдаж байна.

Гэтэл энэхүү судалгааны дүнгээр танин мэдэхүйн болон сургалтын зорилготой мэдээллүүд хамгийн бага хувьтай байгаа тухай өмнөх хэсгүүдэд дурьдсан билээ.

<sup>5</sup> Энгийн мэдээллийн хэлбэртэй байгаль орчны сэдэвт мэдээллийн 98,6 хувь нь энгийн ойлгомжтой байж чаддаг бол 1,4 хувь нь ойлгомжтой байж чадахгүй байна гэх мэтээр уншина.

Хүснэгт 11.

**Өдөр тутмын сонин тус бүрийн байгаль орчны сэдэвт  
мэдээллийн чанарын зарим үзүүлэлтүүд**  
*/Эерэг утгын харьцуулалтаар/*

	Өнөөдөр	Зууны мэдээ	Өдрийн сонин	Ардын эрх	Улаанбаатар таймс	Өнөөдрийн монгол
Энгийн ойлгомжтой	97,5	100,0	77,8	97,9	100,0	100,0
Сонирхолтой	62,9	100,0	55,6	100,0	62,8	67,9
Үр өгөөжтэй	64,2	98,1	55,6	90,3	79,8	79,5
Шийдэл оновчтой	97,5	100,0	55,6	81,5	100,0	100,0
Мэдээллийн хэмжээ агуулгатайгаа тохирсон	100,0	99,4	79,0	87,5	100,0	100,0
Найруулга хангалттай	100,0	100,0	98,9	96,7	100,0	98,7
Үгийн сонголт оновчтой	100,0	99,4	65,4	90,0	100,0	100,0
Ойлгомжгүй сунжруу өгүүлбэрээс зайлс хийсэн	97,5	99,4	70,4	100,0	100,0	100,0
Техникийн тайлбаргүй нэр томъёо ашиглаагүй	98,7	98,9	75,3	63,6	100,0	100,0
Залхмаар урт сунжруу ишлэлээс зайлс хийсэн байдалтай	97,5	98,9	78,3	100,0	100,0	100,0
Тодорхой баримтад тулгуурласан	94,3	88,3	88,4	100,0	98,4	97,4
Цаг үедээ тохирсон шуурхай	100,0	100,0	63,3	97,9	100,0	100,0
Сонин тус бүрийн байгаль орчны сэдэвт мэдээллийн чанарын дундаж үзүүлэлт	92,5	94,8	68,0	92,1	95,1	95,3
Өдөр тутмын сонины байгаль орчны сэдэвт мэдээллийн чанарын дундаж үзүүлэлт	89,6					

Сонин тус бүрийн байгаль орчны сэдэвт мэдээллийн чанарын дундаж үзүүлэлтэд тулгуурлан өдөр тутмын зургаан сонинг эерэгээс сөрөг рүү эрэмбэлвэл дараах байдалтай байна.

1. Өнөөдрийн монгол  
2. Улаанбаатар таймс  
3. Зууны мэдээ  
4. Өнөөдөр  
5. Ардын эрх  
6. Өдрийн сонин орж байна.

Мөн өдөр тутмын сонины байгаль орчны сэдэвт мэдээллийн чанарыг гоон үзүүлэлтээр илэрхийлбэл 100 баллын үндсэнээс 89,6 баллтай байна.

## ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

- Өдөр тутмын сонины байгаль орчны сэдэвт мэдээллүүдийг бичлэгийн төрөл, хэлбэрээр нь авч үзвэл хамгийн олон давтамжтай нь мэдээ /61.6 хувь/ байгаа бол дунджаар хамгийн их талбайтай нийтлэгддэг нь хэлэлцүүлэг, өгүүллүүд байна.

- Мэдээллийг чанарын талаас нь авч үзвэл юун түрүүнд байгаль орчны сэдэвт мэдээллийг уншигчдад хүрэх үр өгөөж болон сонирхолтой байлгах тал дээр анхаарах хэрэгтэй. Мэдээллийн чанарын эдгээр үзүүлэлтүүд нь бусдаасаа харьцангуйгаар хангалтгүй байна. Бичлэгийн төрлүүдээс хамгийн олон давтамжтай гардаг Мэдээний үр өгөөж хангалтгүй байгааг анхаарах хэрэгтэй.

- Судалгаа болон статистик тоо баримтад тулгуурласан байгаль орчны сэдэвт мэдээллүүдийг баримтжуулалт сайтай хэмээн үзвэл энэ хэсэг нь нийт мэдээллийн гуравны нэгийг эзэлж байна.

- Байгаль орчны сэдэвт өгүүлэл, нийтлэл зэрэг нь статистик тоо баримт, судалгааны материалд илүү тулгуурласан байгаа нь сайшаалтай ч тухайн тоо баримтаа ямар эх сурвалж, материалаас авсанаа бүрэн тодорхойлж, тэмдэглэж байх тал дээр анхаарах шаардлагатай.

- Судалгааны дүнгээс үзвэл нийт мэдээллийн 93.4 хувь нь шууд, 6.6 хувь нь дам байдлаар хүрчээ. Дам хэлбэрээр хүрсэн мэдээллүүд дундаа байгалийн баялаг, ашигт малтмалын орд газруудтай

холбогдсон асуудлууд голлож байлаа.

- Мэдээллийн хэлбэр талаасаа энгийн мэдээллийн хэлбэртэй хэсэг нь харьцангуйгаар үр өгөөж багатай байсан бол сургалт болон танин мэдэхүйн хэлбэртэй мэдээллүүд нь уншигчдад илүүтэйгээр хүрч тэдний байгаль орчны талаарх мэдлэг мэдээллийг зүй зохистой, төлөвшүүлэх бололцоог өөртөө агуулж байдаг байна. Гэсэн ч судалганы дүнгээр танин мэдэхүйн болон сургалтын хэлбэртэй мэдээллүүд хамгийн бага талбайг эзэлж байгааг анхаарах хэрэгтэй.

- Түүнчлэн хүн ба байгалийн шүтэлцээ холбоо талаасаа сонины байгаль орчны сэдэвт мэдээллүүдээс байгаль дэлхийгээс хүмүүст хүргэсэн сөрөг үр дагаврын тухай мэдээлэл тал орчим хувийг эзэлж байна.

- Мөн нийт мэдээллийн 80 орчим хувийнх нь эх сурвалж тодорхой буюу ил байлаа.

- Өнөөдрийн Монгол, Улаанбаатар таймс зэрэг сонинууд мэдээллийн чанарын нийлбэр үзүүлэлтээр бусдаасаа давуу байсан бол Зууны мэдээ, Ардын эрх зэрэг сонинуудын байгаль орчны сэдэвт мэдээллийн үр өгөөж болон уншигчдад хүрэх үзүүлэлтүүд нь хангалттай түвшинд байв.

Мэдээллийн хэлбэр талаас нь хандвал сургалт болон танин мэдэхүйн хэлбэртэй байгаль орчны сэдэвт мэдээллүүд нь илүү сонирхолтойн дээр үр өгөөжтэй байсан ч бусад мэдээллүүдтэй харьцуулбал давтамж, талбайн хувьд бага хувийг эзэлж байна.

## ХАВСРАЛТ

### Шинжилгээний категориуд

Асуудалд аль субъектрүү хандсан:

/Тухайн асуудлыг хэнд хүргэхийг зорьсон тухай./

1. Тодорхой нэг хувь хүнд хандсан
2. Хүүхэд залуучуудад хандсан
3. Улс төрчид, нийгмийн удирдах түвшнийхэнд хандсан
4. Бизнес, аж ахуйн нэгж, хувийн хэвшлийнхэнд хандсан
5. Олон нийтэд хандсан

Байгаль орчны талаарх мэдээллийн хамрах хүрээ

1. Нутаг орны чанартай /Дотоодын хот, аймаг, сум, дүүрэг гм/
2. Бүс нутгийн чанартай /Дотоод-төвийн, зүүн гэх мэт/
3. Улсын чанартай /Дотоод-нийт үндэсний шинж чанартай/
4. Гадаадын тодорхой нэг улсын чанартай /Америк, Хятад гм/
5. Дэлхий нийтийн чанартай

Сэдвийн агуулга:

1. Байгаль хамгаалал
2. Ой, ойн хомсдол
3. Хог хаягдал
4. Агаарын бохирдол
5. Хөрсний бохирдол
6. Ургамал ан амьтан
7. Улсын тусгай хамгаалалттай газар /Дархан цаазат газар, цогц газар гм/
8. Ашигт малтмал
9. Байгалийн гамшиг
10. Хорт бодис
11. Озоны давхарга
12. Цөлжилт, хөрсний илэгдэл
13. Усны бохирдол
14. Цаг аргаарын өөрчлөлттэй холбоотой мэдээлэл
15. Бусад

Мэдээллийн хандлага:

1. Эерэг /100000 мод үрслүүлж байна гм/
2. Төвийг сахисан /Эерэг болон сөрөг аль алиныг нь агуулсан/
3. Сөрөг /Тужийн нарс дуусч байна гэх мэт/

Мэдээллийн өнцөг:

/Тухайн асуудалд аль өнцгөөс нь хандаж байгааг тодруулах. Өөрөөр хэлбэл байгаль орчны эрх зүйн, эдийн засгийн үр өгөөжийн асуудал хөндсөн гэх мэт/

1. Эдийн засаг
2. Улс төр
3. Нийгмийн /Эрүүл мэнд, боловсрол, хууль эрх зүй/
4. Оюун санаа /Байгаль хамгаалах ёс зүй, ухамсар сэтгэхүйн нөлөө/

Сонины мэдээллийн чанарыг

хэмжих зарим үзүүлэлтүүд:

1. Мэдээллийн агуулга энгийн ойлгомжтой байсан
2. Мэдээлэл хүмүүсийн анхаарлыг татахуйц сонирхолтой байсан
3. Мэдээлэл үр өгөөжтэй байсан<sup>3</sup>
4. Мэдээллийн шийдэл оновчтой байсан
5. Мэдээллийн хэмжээ агуулгатайгаа тохирсон
6. Мэдээллийн найруулга хангалттай байсан
7. Мэдээлэлд хэрэглсэн үгийн сонголт оновчтой байсан
8. Ойлгоход хэцүү сунжруу өгүүлбрүүдээс зайлс хийсэн байдалтай
9. Техникийн тайлбаргүй нэр томъёо ашиглаагүй
10. Залхмаар урт сунжруу ишлэлээс зайлсхийсэн эсэх

Сонины мэдээллийн хэлбэр:

1. Энгийн мэдээллийн хэлбэртэй / Газар хөдөлжээ гм/
2. Асуудал хөндсөн /Аливаа тулгамдсан асуудлын шийдлийг гаргахыг зорьсон/
3. Сургалт, сурталчилгаа, сэрэмжийн хэлбэртэй / Газрыг хэрхэн зөв зүйтэй ашиглах вэ, байгальтай яаж харьцвал зүйтэй, ил гал бүү хая, хогоо хамаагүй газар хаяж болохгүй гм/
4. Танин мэдэхүйн хэлбэртэй / Амьтны ертөнц, байгалийн үзэсгэлэнт газар орон гм/

Хүн байгалийн шүтэлцээ, холбооны талаарх мэдээллийн тэнцвэртэй байдал

1. Байгаль орчин нь хүний амьдралд хүргэж байгаа ач тусын талаарх эерэг мэдээлэл /Ургац, рашаан, амралт сувилгааны талаар/
2. Хүний байгаль орчинтой холбогдох үйл ажиллагааны талаарх эерэг мэдээлэл /Мод бут тарьсан, хог цэвэрлэв гм/
3. Байгалиас хүмүүст хүргэсэн сөрөг үр дагаврын тухай мэдээлэл /Байгалийн гамшиг, үер ус, хэт дулаарал/
4. Хүнээс байгаль орчинд хүргэж байгаа сөрөг үр дагаврын талаарх мэдээлэл /Хог, утаа, нөхөн сэргээлтгүй газар гм/

Сургалт сурталчилгаа, сэрэмжийн мэдээллийн хамрах хүрээ

1. Байгаль орчны сэдэвтэй эрдэм шинжилгээний бүтээл, шинэ туршилт ололтууд
2. Олон нийтэд хандаж сурталчилсан байдал
3. Өдөр тутмын ахуй амьдралд хэрэглэгдэх боломжийг агуулсан
4. Бодит байдалд хэрэгжсэн тохиолдлууд

Мэдээллийн эх сурвалж тодорхой эсэх

1. Ил /Эх сурвалжийн нэрийг дурьдах баталгаажуулах/
2. Далд /Эх сурвалжаа ерөнхийд нь тодруулж нэргүй иш татна. Ж и ш э э нь: Засгийн газрын нэг томоохон албан тушаалтны хэлснээр гэх мэт/
3. Далдын далд /Сэтгүүлч тухайн мэдээллийг ашигласан боловч ямар эх сурвалжаас авснаа хэлэхгүй, тодорхойгүй байх. Жишээ албан ёсны эх сурвалжаар бол, нэг эх сурвалжийн мэдээллсэнээр гм
4. Эх сурвалж тодорхойгүй /Эх сурвалжаас авсан эсэх нь тодорхойгүй байх/

Бичлэгийн төрөл

1. Мэдээ
2. Сурвалжлага
3. Нийтлэл / өгүүлэл
4. Ярилцлага
5. Хөрөг
6. Захидал санал
7. Тэмдэглэл
8. Редакцийн өгүүлэл
9. Хэлэлцүүлэг
- 10.Эрэн сурвалжилсан өгүүлэл

Бичлэгийн хэлбэр

1. Статистик тоо баримтад тулгуурласан
2. Судалгааны материал тулгуурласан
3. Ишлэл яриа
4. Мэдээлэл ажиглалт
5. Бусад . . . . .

Асуудлыг уншигчдад хүргэх аргачлал

1. Шууд / Богд ууланд 1000 мод үрслүүлээ /
2. Дам /Есөн эрдэнийн өнгөтэй есөн зүйл сум минь, Ноён Поушокын түрэмгийлэл зэрэгт асуудлыг шууд тодорхойлж хэлэлгүйгээр түүний илрэл болж байгаа зүйлүүдийг тоочин өгүүлсэн байдалтай/

#### (Footnotes)

<sup>3</sup> Хүний амьдралд шууд болон шууд бус утгаараа ихээхэн ашиг тус /хор хохирол/ болох боломжийг агуулсан мэдээлэл юм. Тухайлбал Японд Цунамигийн аюул нүүрэлжээ, 50 халим амиа хоролжээ зэрэг мэдээллээс илүүтэйгээр УБ-чуудаа өвлийн улиралд нэмэгдэх хорт утаанд өглөө орой амны хаалттай явах нь уушигны өвчлөлөөс сэргийлнэ, Хэрхэн үрслүүлэг хийх вэ /ногоо тариалахтай холбоотой/ гэх мэт мэдээллүүд нь үр өгөөжтэй шүү дээ.





**ТЕЛЕВИЗИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ  
СЭДЭВТ  
МЭДЭЭЛЭЛД  
ХИЙСЭН  
ШИНЖИЛГЭЭ**

**3.**

## I. Телевизийн мэдээлэл дэх байгаль орчны талаарх мэдээллийн тоон үзүүлэлт

### Байгаль орчны холбогдолтой мэдээллийн эзлэх хэмжээ

Дурын нэг долоо хоногийн хугацаанд Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг зургаан телевизээр гарсан байгаль орчны /БО/ талаарх мэдээллийг зарим статистик үзүүлэлтүүдээр гаргавал:

#### Хүснэгт 1.

#### Долоо хоногт телевизээр гарсан байгаль орчны мэдээллийн хэмжээ /Минутаар/

Телевиз	Давтамж	Хувь
Монголын Үндэсний телевиз	18	10,3
МН 25-р суваг телевиз	30	17,2
ТВ5 телевиз	28	16,1
ТВ 9 телевиз	23	13,2
UBS телевиз	33	19,0
Ийгл бродкастинг телевиз	42	24,1
<b>Нийт</b>	<b>174</b>	<b>100,0</b>

#### Хүснэгт 2.

#### Долоо хоногт телевизээр гарсан байгаль орчны мэдээллийн хэмжээ /Минутаар/

Телевиз
Монголын Үндэсний телевиз
МН 25-р суваг телевиз
ТВ 5 телевиз
ТВ 9 телевиз
UBS телевиз
Ийгл бродкастинг телевиз
<b>Нийт</b>

<sup>1</sup> Нэг нэвтрүүлгийн үргэлжлэх дундаж хугацаанд стандарт хазайлт ихтэй тул арифметик дунджийг авч хэрэглэхэд боломжгүй учраас мод, медианыг ашиглаж, нэвтрүүлгийн төрөл тус бүрээр бодсон болно. Социологит дундаж үзүүлэлтийг юун түүрүүнд арифметик дундаж болон мод, медианаар гаргадаг билээ. Мод нь хамгийн их давтагдаж байгаа хугацаа бол медиан нь БО-сэдэвт мэдээллийн нийт давтамжийг хоёр тэнцүү хэсэгт хувааж байгаа хугацаа болно./Жнь: БО-ы сэдэвт мэдээллүүд нь 1, 1, 2, 3, 4 минутаар цацагдсан гэж үзвэл мод нь 1, медиан нь 2, арифметик дундаж нь  $(1+1+2+3+4)/5=2.2$  болно/

Телевизүүдэд ажиглалт хийсэн долоо хоногийн хугацаанд байгаль орчны талаарх нийт 174 ширхэг мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг гарчээ. Байгаль орчны талаарх мэдээллийг хамгийн олон удаа үзэгчиддээ хүргэсэн телевиз нь Ийгл бродкастинг телевиз 42 удаа нэвтрүүлсэн бол түүний дараагаар UBS телевиз 33, 25-р суваг телевиз 30, ТВ5 телевиз 28, ТВ9 телевиз 23, Монголын Үндэсний телевиз 18 удаа цацжээ.

Байгаль орчны талаарх мэдээлэлд зарцуулсан хугацаагаар нь авч үзвэл нийт 809 минут буюу 13.5 цагийн хөтөлбөр гарснаас Ийгл бродкастинг телевиз 251 минут /4.2 цаг/, ТВ9 телевиз 237 минут

/3.9 цаг/, UBS телевиз 153 минут /2.5 цаг/, Монголын Үндэсний телевиз 82 минут /1.4 цаг/, ТВ5 телевиз 56 минут /0.9 цаг/, 25-р суваг телевиз 31 минут /0.5 цаг/ нь байна.

Дунджаар 1-2 минутын хэмжээтэй мэдээнүүд дийлэнх буюу 82.2 хувийг эзэлж байна. Үлдсэн 17.8 хувь нь байгаль орчны талаарх боловсрол танин мэдэхүйн /3.4 хувь/, хүүхэд залуучуудын /1.7 хувь/, нийгэм улс төрийн /6.9 хувь/, баримтат кино /4 хувь/, зар мэдээллийн чанартай /1.7 хувь/ зэргээр хуваарилагдана. Зар сурталчилгаа эс тооцвол бусад нэвтрүүлгүүд дунджаар 4-16 минутын хэмжээтэй байв.

### Хүснэгт 3.

#### Нэвтрүүлгийн төрөл телевиз тус бүрээр /Давтамж/

Телевиз	Хүүхэд залуучуудын	Боловсрол танин мэдэхүйн	Мэдээ	Нийгэм, улс төрийн	Баримтат кино	Зар мэдээллийн	Бусад нэвтрүүлэг
Монголын Үндэсний телевиз	2	1	14	1			4
25-р суваг телевиз			30				0
ТВ 5 телевиз	1		24	3			4
ТВ 9 телевиз		2	12	2	7		11
UBS телевиз		3	25	5			8
Ийгл бродкастинг телевиз			38	1		3	1
<b>Нийт</b>	<b>3</b>	<b>6</b>	<b>143</b>	<b>13</b>	<b>7</b>	<b>3</b>	<b>18</b>

Ийгл бродкастинг телевизээр байгаль орчны тухай мэдээ болон зар мэдээлэл хамгийн олон давтамжтайгаар гарсан байгаа бол ТВ9, UBS зэрэг телевизүүдээр байгаль орчны холбогдолтой хүүхэд залуучуудын, боловсрол танин мэдэхүйн, нийгэм улс төрийн болон баримтат кино хэлбэрээр илүүтэй гарсан байна. Ажиглалт хийсэн долоо хоногийн хугацаанд телевизийн нийт нэвтрүүлгүүд нь дараах байдлаар гарчээ.

Энэхүү мэдээлэлд тулгуурлан телевизийн нэвтрүүлэгт байгаль орчны талаарх мэдээлэл хичнээн хувийг эзэлдгийг тооцооллоо.

**Хүснэгт 4. Ажиглалтын долоо хоногт телевизээр гарсан нэвтрүүлгийн хэмжээ /цагаар/**

Сар / өдөр		I/18	I/19	I/20	I/21	I/22	I/23	I/24	I/25
Телевиз	Гариг	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Даваа	Мягмар	Лхагва
Монголын Үндэсний телевиз		17	17.9	17.2	17	17.3	10.5	18	17
25-р суваг телевиз		17	17	16.5	17.5	16	16.5	17.5	17
ТВ 5 телевиз		17	16.6	18	16.5	16.5	16.8	16.8	17
ТВ 9 телевиз		24	24	24	24	24	24	24	24
UBS телевиз		18.7	18.1	18.7	18.7	18.1	10.5	18.3	18.7
Ийгл бродкастинг телевиз		24	24	24	24	24	24	24	24


**Хүснэгт 5.**

**Телевизийн нэвтрүүлэгт байгаль орчны тухай мэдээллийн эзлэх хувь /Хувиар/**

Дээрх хүснэгтүүдээс харахад байгаль орчны талаарх телевизийн мэдээлэл нийт нэвтрүүлгийн цагийн дунджаар 1.6 хувьтай тэнцэж байна. Байгаль орчны талаарх мэдээлэл нь ихэвчлэн мэдээ хэлбэрээр гарах бөгөөд Мэдээний суваг гэж болох Ийгл бродкастинг телевизээр байгаль орчны талаарх мэдээлэл илүүтэй гарчээ.

**График 1.**

**Телевизийн нэвтрүүлэгт байгаль орчны тухай мэдээллийн эзлэх хувь**



МҮТВ
25-р суваг
ТВ5 телевиз
ТВ 9 телевиз
UBS телевиз
Ийгл теле

## Байгаль орчны талаарх мэдээллийн агуулга ба хандлага

Байгаль орчны тухай телевизийн нэвтрүүлэгт задлан шинжилгээ хийж мэдээллийн агуулга, эерэг сөрөг хандлагыг тодруулах нь мэргэжилтнүүд болон үзэгчдийн хувьд ач холбогдолтой.

Сүүлийн жилүүдэд хүний зүй бус үйл ажиллагаанаас улбаалсан ой хээрийн түймэр, ус, агаарын бохирдол зэрэг байгаль орчны асуудлууд цаашлаад дэлхийн хэт дулаарал, цөлжилт, ан амьтдын элдэв төрлийн өвчин эмгэг зэрэг байгаль орчны сөрөг үзэгдлүүд өргөжиж байгаатай холбоотой байгаль орчны тухай телевизийн мэдээллийн хандлага сөрөг талаар давамгайлж /55.0 хувь/ байна. Эерэг /39.2 хувь/ болон төвийг сахисан /5.8 хувь/ мэдээлэл бага хувьтай байна.

Нэвтрүүлгүүдийг агуулгаар нь

ангилж үзвэл үер ус, зуд турхан, ган гачиг, далайн хар салхи, галт уул дэлбэрэлт, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотой мэдээлэл хамгийн их буюу нийт мэдээллийн тавны нэгийг эзэлж байна. Үүний дараа зэрлэг ан амьтан, байгаль хамгаалалтай холбоотой мэдээлэл 19.4 хувь, мал амьтны тухай 14.8 хувь, ашигт малтмалын орд, түүний ашиглалтын тухай 9.7, газар зүйн бүс онгон байгалийн тухай 6.9 хувь байх жишээтэй. /Дэлгэрэнгүйг Хүснэгт 6-аас үзнэ үү.

Жич: Эерэг хандлагатай мэдээлэлд гамшигт үзэгдэл, хотын бохирдол, хог хаягдлын талаар нааштай мэдээллүүдийг хамруулсан болно. Тухайлбал зам гүүр, гудамж талбай, гол, мөрний хог, хаягдлыг цэвэрлэх гэх мэт/

### Хүснэгт 6.

#### Нэвтрүүлгийн агуулга ба хандлага

	<i>Хандлага</i>	<i>Эерэг</i>	<i>Сөрөг</i>	<i>Товч</i>	<i>Нийтхувь</i>
	<i>Мэдээллийн агуулга</i>				
1	Байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотой мэдээлэл	5	44		22,7
2	Зэрлэг ан амьтан, байгаль хамгаалал	25	17		19,4
3	Мал амьтны тухай	2	26	4	14,8
4	Ашигт малтмалын орд газар	10	8	3	9,7
5	Газар зүйн бүс, онгон байгаль	13	2		6,9
6	Хорт бодис	4	7		5,1
7	Экологийн тэнцвэр	3	5	1	4,2
8	Ус, усны бохирдол	3	4	2	4,2
9	Хотын бохирдол, хог хаягдал	5	3		3,7
10	Ой мод, ойгүйжилт		5	1	2,8
11	Цаг агаарын өөрчлөлт	4			1,9
12	Агаарын бохирдол		3		1,4
13	Дархан цаазат газар, бүс нутаг	1	2		1,4
14	Газар, хөрс, цөлжилттэй холбоотой	1	2		1,4
15	Озоны давхарга		1		0,5
	Нийт хувь	39.2	55.0	5.8	

## Байгаль орчны талаарх мэдээллийн субъект ба хамрах хүрээ

Телевизээр гарч байгаа байгаль орчны тухай мэдээллийн зорилтот субъект нь ихэвчлэн /86.5 хувь/ олон нийт байдаг байна. Түүний дараа тодорхой бүлэг хүнд хандсан 5.8 хувь, төрийн удирдах шатны болон хууль хяналтын байгууллагуудад хандсан 3.5 хувь, хувийн хэвшлийнхэнд хандсан 2.3 хувь, төрийн бус олон нийтийн байгууллагуудад хандсан 1.8 хувьтай байна.

Байгаль орчны сэдэвтэй телевизийн мэдээллийн талаас илүү хувь нь гадаадын тодорхой нэг улс орны /55.6 хувь/ тухайн байсан бол олон улсын /15.2 хувь/, дэлхий нийтийн чанартай /10.5 хувь/ ажээ. Харин улсын чанартай

дотоодын мэдээ 26.6 хувийг эзэлж байв.

ТВ-ийн мэдээллүүдийг агуулга болон газар зүйн хамрах хүрээгээр нь бүлэглэж үзвэл сонирхолтой дүр зураг харагдана. Гадаадын, олон улсын, дэлхий нийтийн чанартай мэдээллүүд нь байгалийн гамшигт үзэгдэл, зэрлэг ан амьтан, байгаль хамгаалал, хорт бодис, усны хомсдол, бохирдол, экологийн тэнцвэрт байдлын тухай байгаа бол дотоодын мэдээллүүд нь ашигт малтмалын орд, түүний ашиглалттай холбоотой, мал амьтны тухай, хотын бохирдол хог хаягдлын тухай байна.

### Хүснэгт 7.

#### Байгаль орчны тухай мэдээллийн агуулга ба газар зүйн хамрах хүрээ

	Мэдээ
1	Байгаль үзэгдэл мэдээ
2	Зэрлэг хамга
3	Мал а
4	Ашиг
5	Газар байга
6	Хорт
7	Эколо
8	Ус, ус
9	Хотын хаягд
10	Ой мо
11	Цаг а
12	Агаар
13	Дарха нутаг
14	Газар холбо
15	Озон
	Нийт

## Байгаль орчны холбогдолтой мэдээллийн өнцөг ба хэлбэр


Байгаль орчны тухай мэдээллийн өнцөг нь байгаль орчны талаарх үзэгдэл, үйл явдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улс төр, эдийн засаг, эрүүл ахуй, хүмүүсийн ахуй амьдрал зэрэг олон талт үзэгдлийн аль талаас нь хөндөж

бичсэнээс ихээхэн шалтгаална.

Телевизийн хувьд байгаль орчны талаарх мэдээллийн өнцөг нь хүн, амьтны эрүүл ахуй /33.8 хувь/ болон эдийн засгийн /21.2 хувь/ талаасаа харьцангуй өндөр хувьтай гарчээ.

**График 2.**

**Байгаль орчны тухай мэдээллийн хандлага /Хувиар/**



Дээрх үзүүлэлтүүдийг агуулгаар нь харьцуулж үзвэл агаарын бохирдол, газар хөдлөлт, хар салхи, үер усны аюул зэрэг байгалийн гамшигт үзэгдлүүдэд эрүүл ахуйн талаас нь, харин байгалийн баялаг, ашигт малтмалын орд газар зэрэгт эдийн засаг, улс төрийн өнцгөөс нь мэдээлсэн байх жишээтэй.

Байгаль орчны тухай мэдээллийг үзэгчдэд хүргэж байгаа хэлбэрийн нь үүднээс авч үзвэл энгийн мэдээллийн шинжтэй 74.3 хувь, танин мэдэхүйн хэлбэртэй 12.3 хувь, сурталчилгаа, сэрэмжлүүлгийн хэлбэртэй 7.0 хувь, сургалтын хэлбэртэй 6.4 хувьтай байна.



**Хүснэгт 8.**

**Байгаль орчны талаарх мэдээллийн хэлбэр  
/Хувиар/**

	<i>Энгийн мэдээллийн чанартай</i>	<i>Сургалтын чанартай</i>	<i>Сурталчилгаа, сэрэмжийн чанартай</i>	<i>Танин мэдэхүйн чанартай</i>	<i>Нийт</i>
Монголын үндэсний телевиз	13 72,2%		3 16,7%	2 11,1%	18 100,0%
25-р суваг телевиз	28 93,3%			2 6,7%	30 100,0%
ТВ 5 телевиз	20 71,4%	1 3,6%	2 7,1%	5 17,9%	28 100,0%
ТВ 9 телевиз	3 13,0%	8 34,8%	7 30,4%	5 21,7%	23 100,0%
UBS телевиз	24 72,7%	2 6,1%		7 21,2%	33 100,0%
Ийгл бродкастинг телевиз	39 100,0%				39 100,0%
Нийт	127 74,3%	11 6,4%	12 7,0%	21 12,3%	171 100,0%

Мэдээллийн зорилгыг телевиз тус бүрээр харьцуулж үзвэл Ийгл бродкастинг телевиз 100 хувь энгийн мэдээллийн хэлбэртэй байхад, ТВ9 телевизийнх энгийн мэдээллийн хэлбэртэй /13 хувь/, сургалтын хэлбэртэй /34.8 хувь/, сурталчилгаа сэрэмжийн хэлбэртэй /30.4 хувь/ танин мэдэхүйн хэлбэртэй /21.7 хувь/байгаа нь нэвтрүүлгүүд нь харьцангуй тэнцвэртэй жигд тархалттай байгааг илтгэнэ.

## ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Бидний ажиглалт хийсэн нэг долоо хоногийн хугацаанд Монголын Үндэсний телевиз, Ийгл бродкастинг телевиз, UBS телевиз, 25-р суваг телевиз, ТВ 9 телевиз, ТВ5 телевиз зэрэг 6 телевизээр нийт 174 удаагийн байгаль орчны сэдэвтэй мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгүүд гарсан болно.

- Судалгааны дүнгээр байгаль орчны сэдэвт мэдээллүүд телевизийн нэвтрүүлгийн нийт цагт эзлэх хэмжээ нь дунджаар 1.6 хувь байна.

- Дунджаар 1-2 минутын мэдээ, мэдээллийн хөтөлбөрүүд дийлэнх буюу 82.2 хувийг эзэлж, үлдсэн 17.8 хувь нь байгаль орчны талаарх боловсрол танин мэдэхүйн 3.4 хувь, хүүхэд залуучуудын 1.7 хувь, нийгэм улс төрийн 6.9 хувь, баримтат кино 4 хувь, зар мэдээллийн чанартай 1.7 хувь зэргээр хуваарилагдана. Зар мэдээллийг эс тооцвол эдгээр нэвтрүүлгүүд нь дунджаар 4-16 минутын хэмжээтэй байдаг.

- Нийт нэвтрүүлэгт эзлэх байгаль орчны тухай мэдээллийн хувь хамгийн өндөр телевиз Ийгл бродкастинг ТВ бол байгаль орчинтой холбоотой энгийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, танин мэдэхүйн хэлбэртэй мэдээллүүд нь хамгийн жигд хэмжээтэй нь ТВ 9 байв.

- Сүүлийн жилүүдэд хүний зүй бус үйл ажиллагаанаас улбаалсан ой хээрийн түймэр, ус, агаарын бохирдол зэрэг байгаль орчны асуудлууд цаашлаад дэлхийн хэт дулаарал, цөлжилт, ан амьтдын элдэв төрлийн өвчин эмгэг зэрэг байгаль орчны сөрөг үзэгдлүүд өргөжиж байгаатай холбоотойгоор байгаль орчны тухай телевизийн мэдээлэл хандлагын хувьд сөрөг тал нь давамгайлж /55.0 хувь/ байна. Эерэг /39.2 хувь/ болон төвийг сахисан /5.8 хувь/ мэдээлэл харьцангуй бага хувьтай.

- Нэвтрүүлгүүдийг агуулгаар нь

ангилж үзвэл үер ус, зуд турхан, ган гачиг, далайн хар салхи, галт уул дэлбэрэлт, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотой мэдээлэл харьцангуй их буюу 22.7 хувийг эзэлж, түүний араас зэрлэг ан амьтан, байгаль хамгаалалтай холбоотой мэдээлэл 19.4 хувь, мал амьтны тухай 14.8 хувь, ашигт малтмалын орд, түүний ашиглалтын тухай 9.7, газар зүйн бүс онгон байгалийн тухай 6.9 хувь байх жишээтэй.

- Телевизүүдээр гарч байгаа байгаль орчны сэдэвтэй дийлэнх мэдээллүүд нь олон нийтэд хандсан /86.5 хувь/ нөгөөтэйгүүр хамрах газар зүйн хүрээний хувьд гадаадын тодорхой нэг улс орны /55.6 хувь/ чанартай бөгөөд харин дотоод мэдээ 26.6 хувийг эзэлдэг.

- Мэдээллийн дийлэнх хувь нь олон нийтэд чиглэсэн нь мэдээллийн ач холбогдлыг бууруулж болох талтай. Аливаа юм тодорхой хил хязгаартай байж үнэ цэнэ, ач холбогдол нь өсдөгтэй адил дээрх мэдээллүүдээ улс төрийн нам хүчин, хүүхэд залуус, тариаланчдад, бүр хүлэмжийн ногоо тариалагчдад гэх мэтээр тодорхой бүлгээр хайрцаглаж өгвөл илүү үр дүнтэй байна.

Мөн байгаль орчны тухай мэдээллийн өнцөг нь хүн, амьтны эрүүл ахуй /33.8 хувь/ болон эдийн засгийн /21.2 хувь/ талаасаа харьцангуй өндөр хувьтай байдаг ажээ.

## II. ТЕЛЕВИЗИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ БА СЭТГҮҮЛ ЗҮЙН ШААРДЛАГА, ХЭРЭГЦЭЭ


### Байгаль орчны талаарх мэдээллийн чанарын зарим үнэлгээ

Бид хэвлэл мэдээллийн хэрэгслээр тэр дундаа телевизээр гарч байгаа байгаль орчны талаарх мэдээллийн чанарыг юуны өмнө агуулга нь энгийн ойлгомжтой эсэх, хүмүүсийн анхаарлыг татахуйц сонирхолтой байсан эсэх, үр өгөөжтэй

байсан эсэх, шийдэл нь оновчтой байсан эсэх, нэвтрүүлгийн хугацаа агуулгатай тохирсон эсэх, нэвтрүүлгийн найруулга хангалттай байсан эсэх зэрэг шалгууруудаар үнэлсэн билээ.

График 3.

Нэвтрүүлгийн чанарын зарим үзүүлэлтүүд



Телевизээр гарч байгаа байгаль орчны талаарх мэдээллүүд нь агуулга нь ойлгомжтой, хүмүүсийн анхаарлыг татахуйц сонирхолтой, найруулга хангалттай байж чаддаг боловч нэвтрүүлгийн хугацаа нь агуулгатайгаа тохироогүй, нэвтрүүлэг нь тиймч үр өгөөжтэй<sup>1</sup> байж чаддаггүй аж. Дээрх графикийг уултай зүйрлэвээс телевизүүд цаашид байгаль орчны талаарх мэдээллээ олон нийтэд хэрэгцээтэй, тустай байлгахын тулд уулын бэлээс нь эхлэн анхаарал хандуулах хэрэгтэй байна.

<sup>1</sup> Хүний амьдралд шууд болон шууд бус утгаараа ихээхэн ашиг тус /хор хохирол/ болох боломжийг агуулсан мэдээлэл юм. Тухайлбал Японд Цунамигийн аюул нүүрэлжээ, 50 халим амша хоролжээ зэрэг мэдээллээс илүүтэйгээр УБ-чуудаа өвлийн улиралд нэмэгдэх хорт утаанд өглөө орой амны хаалттай явах нь уушигны өвчлөлөөс сэргийлнэ, Хэрхэн үрслүүлэг хийх вэ /ногоо тариалахдаа холбоотой/ гэх мэт мэдээллүүд нь үр өгөөжтэй шүү дээ.

Хүснэгт 9.

**Байгаль орчны тухай нэвтрүүлгийн төрөл чанарын үзүүлэлтээр**


<i>Н-н төрөл</i> <i>Шалгуур</i>	<i>Хүүхэд залуучуудын</i>	<i>Боловсрол танин мэдэхүйн</i>	<i>Мэдээ</i>	<i>Нийгэм улс төрийн</i>	<i>Баримтат кино</i>	<i>Нийт</i>
Нэвтрүүлгийн агуулга энгийн ойлгомжтой	1	5	99	3	6	114
	16.7%	22.7%	32.7%	12.5%	54.5%	31.1%
Нэвтрүүлэг хүмүүсийн анхаарлыг татахуйц сонирхолтой болсон	1	4	71	11	2	89
	16.7%	18.2%	23.4%	45.8%	18.2%	24.3%
Нэвтрүүлгийн найруулга хангалттай	1	4	51	3	0	59
	16.7%	18.2%	16.8%	12.5%	0%	16.1%
Нэвтрүүлгийн хугацаа агуулгатайгаа тохирсон	0	3	32	2	0	37
	0%	13.6%	10.6%	8.3%	0%	10.1%
Нэвтрүүлгийн шийдэл оновчтой байсан	0	3	29	2	2	36
	0%	13.6%	9.6%	8.3%	18.2%	9.8%
Нэвтрүүлэг үр өгөөжтэй байсан	3	3	21	3	1	31
	50.0%	13.6%	6.9%	12.5%	9.1%	8.5%
<i>Нийт</i>	<b>6</b>	<b>22</b>	<b>303</b>	<b>24</b>	<b>11</b>	<b>366</b>
	<b>1.6%</b>	<b>6.0%</b>	<b>82.8%</b>	<b>6.6%</b>	<b>3.0%</b>	<b>100.0%</b>

Байгаль орчны тухай мэдээллийн чанарын үзүүлэлтийг нэвтрүүлгийн төрөл хэлбэрээр харьцуулан харвал баримтат кино хэлбэрээр хийгдсэн мэдээ, нэвтрүүлгүүд илүү ойлгомжтой бөгөөд шийдэл нь оновчтой байсан бол нийгэм улс төрийн нэвтрүүлгүүд илүү сонирхолтой, боловсрол танин мэдэхүйн нэвтрүүлгүүд хугацаа нь агуулгатайгаа тохирохуйц, хүүхэд залуучуудын нэвтрүүлгүүд илүү үр өгөөжтэй болдог ажээ.

**Байгаль орчны талаарх мэдээллийн эх сурвалж ба мэдээллийн тэнцвэртэй байдал**

График 4.

**Хүн байгалийн шүтэлцээ холбооны талаарх мэдээллийн тэнцвэртэй байдал**




Байгаль орчны тухай мэдээллийг хүн болон байгаль орчны шүтэлцээ холбооны тухай мэдээллийн тэнцвэртэй байдал талаас нь дөрвөн хэв маягт хувааж үзвэл байгаль орчин нь хувь хүн ба нийгмийн амьдрал үйл ажиллагаанд хүргэж буй сөрөг үр дагаврын тухай мэдээллүүд тал хувийг эзэлж байна. Үүнд газар хөдлөлт, далайн хар салхи, хэт дулаарал, шувууны ханиад гэх мэт амьтдын хүнд халдварладаг өвчин эмгэг болон бусад бодитойгоор хэрэгжсэн тохиолдлуудыг авч үзсэн. Дараа нь тавны нэгд хүний байгаль орчинтой холбогдох эерэг үйл ажиллагааны тухай мэдээлэл орж байна. Энэ төрлийн мэдээлэл нь агаарын бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлэлт, байгаль хамгаалал, ой мод модны хулгайчидтай хийх тэмцлийн тухай, мод тарих, ховордсон ан амьтаны үржүүлэг зэрэг мэдээллийг хамаарна. Хүнээс байгаль орчинд хамаарах сөрөг үр дагаврын тухай мэдээлэл нь 17.8 хувийг эзлэх бөгөөд модны хулгай, далай тэнгис, гол, ус, агаарын бохидол, хог

хаягдал, нөхөн сэргээлтгүй байгалийн баялаг, газар ашиглалт, хулгайн ан, мод зэрэг мэдээллүүд багтана. Харин байгаль орчин нь хувь хүн, нийгмийн амьдралд хүргэж байгаа ач тусын талаарх эерэг мэдээллүүд хамгийн бага буюу 10 хувьтай байна. Үүнд тариа ногоо, ашигт малтмал, хоол хүнс, ахуй амьдралын хэрэглээ болж байгаа тухай мэдээллүүдийг багтаасан.

Байгаль орчны тухай мэдээллийн 60 орчим хувийн эх сурвалж ил буюу эх сурвалжийн нэрийг нь дурьдаж баталгаажуулсан бол үлдсэн 21.2 хувь нь далд /эх сурвалжаа ерөнхийд нь тодруулж нэргүй иш татсан. Жнь: засгийн газрын нэгэн томоохон албан тушаалтны хэлснээр гэх мэт/, мөн 21.2 хувь нь далдын далд /сэтгүүлч тухайн мэдээллийг нэвтрүүлэгт ашигласан боловч ямар эх сурвалжаас авснаа дурьдаагүй/ болон эх сурвалж нь тодорхойгүй /хаанаас авсан тодорхойгүй/ байлаа.

### Байгаль орчны талаарх мэдээлэл ба сэтгүүлчийн ур чадварын зарим үнэлгээ



Сэтгүүлчийн хэллэг ойлгомжтой эсэх, үг ярианы сонголт гэсэн хоёр шалгуураар байгаль орчны мэдээллийг телевизээр дамжуулан олон нийтэд хүргэж байгаа сэтгүүлчдийн ур чадварыг нь үнэлвэл хангалттай хэмжээнд гарчээ. Нийт үнэлгээний 80-90 хувийг сэтгүүлчдийн энэ талын мэдлэг чадвар хангалттай гэсэн үнэлгээ эзэлж байна.

**Хүснэгт 10.**

**Байгаль орчны талаарх мэдээллийг хүргэх сэтгүүлчийн ур чадварын зарим үзүүлэлт / телевиз тус бүрээр/**

Үнэлгээ	Сэтгүүлчийн хэллэг ойлгомжтой эсэх			Сэтгүүлчийн үг ярианы сонголт		
	Хангалттай	Дунд зэрэг	Хангалгүй	Хангалттай	Дунд зэрэг	Хангалгүй
Шалгуурууд						
Телевизүүд						
Монголын үндэсний телевиз	14	4	0	11	2	0
	77,8 %	22,2 %	0 %	84,6 %	15,4 %	0 %
25-р суваг телевиз	30	0	0	30	0	0
	100,0 %	0	0 %	100,0 %	0	0 %
ТВ 5 телевиз	25	3	0	23	0	1
	89,3 %	10,7 %	0 %	95,8 %	0	4,2 %
ТВ 9 телевиз	19	4	0	6	3	0
	82,6 %	17,4 %	0 %	66,7 %	33,3 %	0 %
UBS телевиз	31	2	0	12	1	0
	93,9 %	6,1 %	0 %	92,3 %	7,7 %	0 %
Ийгл бродкастинг телевиз	23	16	0	1	1	0
	59,0 %	41,0 %	0 %	50,0 %	50,0 %	0 %
Нийт	142	29	0	83	7	1
	83,0 %	17,0 %	0 %	91,2 %	7,7 %	1,1%

МН 25-р суваг, ТВ5 телевизийн сэтгүүлчид дээрх үзүүлэлтийн хувьд бусдаасаа харьцангуй дээгүүр үзүүлэлттэй байна.

## ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

- Телевизээр гарч байгаа байгаль орчны сэдэвт мэдээллүүд нь агуулга нь ойлгомжтой, хүмүүсийн анхаарлыг татахуйц, найруулга нь хангалттай байж чаддаг ч хугацаа нь агуулгатайгаа тохирохгүй, дийлэнх мэдээллүүд нь энгийн мэдээллийн чанартай байгаа зэргээс хамаараад үр өгөөжтэй байж чаддаггүй аж.

- Эдгээр үзүүлэлтийг нэвтрүүлгийн төрөл хэлбэрээр нь харьцуулвал баримтат кино хэлбэрээр хийгдсэн нэвтрүүлгүүд илүү ойлгомжтой, шийдэл нь оновчтой байдаг, нийгэм улс төрийн нэвтрүүлгүүд илүү сонирхолтой, боловсрол танин мэдэхүйн нэвтрүүлгүүдийн хугацаа агуулгаа гаргахуйц буюу тохирсон, хүүхэд залуучуудын нэвтрүүлгүүд илүү үр өгөөжтэй байдаг байна.

- Байгаль орчны тухай мэдээллийг хүн болон байгалийн шүтэлцээ холбоо тэнцвэртэй байдал талаас нь дөрвөн хэв маягт хамруулж үзвэл юуны өмнө байгаль орчин нь хувь хүн ба нийгмийн амьдрал үйл ажиллагаанд хүргэж буй сөрөг үр дагаврын тухай мэдээллүүд үнэмлэхүй олонх буюу 50.9 хувийг

эзэлдэг. Харин хүний байгаль орчинтой холбогдох эерэг үйл ажиллагааны тухай мэдээлэл 20.7 хувь байгаа бол хүнээс байгаль орчинд хүргэх сөрөг үр дагаврын тухай мэдээлэл 17.8 хувь, байгаль орчин нь хувь хүн, нийгмийн амьдралд хүргэж байгаа ач тусын талаарх эерэг мэдээллүүд хамгийн бага буюу 10.7 хувьтай байна.

- Байгаль орчны тухай мэдээллийн талаас илүү хувийн /57.6/ эх сурвалж нь ил байна. Энэ нь мэдээллийн агуулгаасаа тэр бүр хамаараад байдаггүй аж.

- Судалгааны дүнгээр байгаль орчны мэдээллийг хүргэж байгаа телевизийн сэтгүүлчдийн ур чадвар хангалттай хэмжээнд байна. Эдгээр үзүүлэлтүүдийн хангалттай гэсэн үнэлгээ үнэмлэхүй хэмжээгээрээ өндөр /83-91.2 хувь/ хувьтай гарчээ. Тухайлбал, МН 25-р суваг, ТВ5 телевизийн сэтгүүлчид байгаль орчны мэдээллийг үзэгчдэд хүргэх ур чадвар талаасаа бусдаасаа харьцангуй дээгүүр үзүүлэлттэй гарсан байна.

## ХАВСРАЛТ

### Шинжилгээний категориуд

Асуудалд аль субъектрүү хандсан:

/Тухайн асуудлыг хэнд хүргэхийг зорьсон тухай/

1. Тодорхой нэг хувь хүнд хандсан
2. Тодорхой бүлэг хүмүүст хандсан
3. Хувийн хэвшилд хандсан
4. Төрийн бус олон нийтийн байгууллагад хандсан
5. Төрийн удирдах шатны болон хууль хяналтын байгууллагад хандсан
6. Олон нийтэд хандсан

Байгаль орчны талаарх мэдээллийн хамрах хүрээ

1. Нутаг орны чанартай /Дотоодын буюу Монголын/
2. Бүс нутгийн чанартай /Дотоод-Төвийн, зүүн гэх мэт/
3. Улсын чанартай /Дотоод/
4. Гадаадын тодорхой нэг улсын чанартай /Америк, Хятад гм/
5. Олон улсын чанартай /Гадаад/
6. Дэлхий нийтийн чанартай

Сэдвийн агуулга:

1. Ойгүйжилт
2. Хотын бохирдол, хог хаягдал
3. Агаарын бохирдол
4. Зэрлэг ан амьтан, байгаль хамгаалал
5. Дархан цаазат газар, бүс нутаг,
6. Газар зүйн бүс, онгон байгаль
7. Экологийн тэнцвэр
8. Ашигт малтмалын орд газар
9. Байгалийн гамшиг
10. Хорт бодис
11. Озоны давхарга
12. Цөлжилт, хөрс
13. Усны бохирдол
14. Мал амьтны өвчин

Мэдээллийн хандлага:

1. Эерэг /100000 мод үрслүүлж байна гм/

2. Сөрөг /Тужийн нарс дуусч байна гм/

3. Төвийг сахисан /Эерэг сөрөг аль алийг нь агуулсан/

Мэдээллийн өнцөг:

/Тухайн асуудалд аль өнцгөөс нь хандаж байгааг тодруулах. Өөрөөр хэлбэл байгаль орчин нь эдийн засгийн ач холбогдолтой, улс төрийн, үндэсний ач холбогдолтой асуудал юм гэх мэт санаа агуулсан эсэхээр/

1. эдийн засаг
2. улс төр
3. эрүүл мэнд
4. үндэсний өв соёл
5. даяаршил, хүн төрөлхтөн
6. ахуй амьдрал

Нэвтрүүлгийн чанарыг хэмжих зарим үзүүлэлтүүд

1. Нэвтрүүлгийн агуулга ойлгомжтой байсан
2. Нэвтрүүлэг хүмүүсийн анхаарлыг татахуйц сонирхолтой байсан
3. Нэвтрүүлэг үр өгөөжтэй байсан
4. Нэвтрүүлгийн шийдэл оновчтой байсан
5. Нэвтрүүлгийн хугацаа агуулгатайгаа тохирсон
6. Нэвтрүүлгийн найруулга хангалттай байсан



#### Нэвтрүүлгийн хэлбэр

1. Энгийн мэдээллийн хэлбэртэй / Газар хөдөлжээ гм/
2. Сургалтын хэлбэртэй /Газрыг хэрхэн зөв зүйтэй ашиглах вэ, байгальтай яаж харьцвал зүйтэй гм/
3. Сурталчилгаа, сэрэмжийн хэлбэртэй /Ил гал бүү хая, хогоо хамаагүй газар хаяж болохгүй гм/
4. Танин мэдэхүйн хэлбэртэй / Амьтны ертөнц, байгалийн үзэсгэлэнт газар орон гм/

#### Хүн байгалийн шүтэлцээ, холбооны талаарх мэдээллийн тэнцвэртэй байдал

1. Байгаль орчин нь хүний амьдралд хүргэж байгаа ач тусын талаарх эерэг мэдээлэл /Ургац, рашаан, амралт сувилгааны талаар/
2. Хүний байгаль орчинтой холбогдох үйл ажиллагааны талаарх эерэг мэдээлэл /Мод бут тарьсан, хог цэвэрлэв гм/

3. Байгалиас хүмүүст хүргэсэн сөрөг үр дагаврын тухай мэдээлэл /Байгалийн гамшиг, үер ус, хэт дулаарал

4. Хүнээс байгаль орчинд хүргэж байгаа сөрөг үр дагаврын талаарх мэдээлэл /Хог, утаа, нөхөн сэргээлтгүй газар гм/

#### Нэвтрүүлгийн эх сурвалж тодорхой эсэх

1. Ил /Эх сурвалжийн нэрийг дурьдах баталгаажуулах/
2. Далд /Эх сурвалжаа ерөнхийд нь тодруулж нэргүй иш татна. Жнь. Засгийн газрын нэг томоохон албан тушаалтны хэлснээр гм/
3. Далдын далд /Сэтгүүлч тухайн мэдээллийг ашигласан боловч ямар эх сурвалжаас авснаа хэлэхгүй, тодорхойгүй байх/

#### Сэтгүүлчийн хэллэг ойлгомжтой эсэх тухай

1. Хангалттай
2. Дунд зэрэг
3. Хангалтгүй

#### Сэтгүүлчийн үг ярианы сонголт

1. Хангалттай
2. Дунд зэрэг
1. Хангалтгүй



# FM-РАДИОГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ СЭДЭВТ МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

# 4.

## I. FM-Радиоогийн мэдээлэл дэх байгаль орчны талаарх мэдээллийн тоон үзүүлэлт

### Байгаль орчны талаарх мэдээллийн эзлэх хэмжээ

Нийт гурван радиод 2006 оны хоёрдугаар сарын 10-17-ны долоо хоногт хийсэн ажиглалтын дүнд байгаль орчны холбогдолтой 68 ширхэг мэдээлэл тэмдэглэгджээ. Тэдгээр мэдээллийг радио тус бүрээр нь харьцуулж үзүүлбэл:

Хүснэгт 1.

FM-Радиоогийн байгаль орчны сэдэвт мэдээллийн давтамж ба талбай /Хувь, Минут/

Радио	Үзүүлэлт	Дундаж хугацаа	Хамгийн бага хугацаа	Хамгийн их хугацаа	Нийт хугацаа	Давтимж	Нийт хугацаанд эзлэх хувь	Давтимж -д эзлэх хувь
Монголын Үндэсний Радио		3,36'	1'	7'	111'	33	41,9%	48,5%
Гэр бүлийн радио FM 104.5		3,68'	1'	20'	103'	28	38,9%	41,2%
Инфо FM 105.5		7,29'	1'	32'	51'	7	19,2%	10,3%
Нийт		3,90'	1'	32'	265'	68	100,0%	100,0%

Үндэсний радиогоор хамгийн олон буюу нийт 33 удаагийн 111 минутын хэмжээтэй байгаль орчны сэдэвт мэдээлэл цацагдсан бол Гэр бүлийн радио FM 104.5-аар 28 удаагийн 103 минут, Инфо FM 105.5-аар 7 удаагийн 51 минутын мэдээлэл цацагджээ. Мэдээллүүд нь хамгийн багадаа 1 минут, хамгийн ихдээ 32 минутын хэмжээтэй бөгөөд нэг

нэвтрүүлэг 3.9 минут үргэлжилдэг байна. Мөн шугмын радиогоор өдөрт дунджаар байгаль орчны сэдэвт нийтдээ 16 минутын таван мэдээлэл явдаг бол, богино долгионы радиогоор 11 минутын хоёр мэдээлэл цацагддаг хэмээн ойлгож болно. Гэвч эдгээр нэвтрүүлгүүд нь тархалтын хувьд нягтрал багатай. Мэдээллийн үргэлжлэх хугацаа нь тухайн нэвтрүүлгийн төрөл хэлбэртэй холбоотойгоор өөрчлөгддөг.

## Хүснэгт 2.

### FM-Радиоогийн нэвтрүүлэгт байгаль орчны тухай мэдээллийн эзлэх хувь

	7 хоногт гарсан дундажцаг	7 хоногт гарсан дундажминут	1 хоногт гарсан дундажцаг	1 хоногт гарсан дундажминут	7 хоногт гарсан Байгаль орчны тухай мэдээллийн нийт минут	1 хоногт гарсан Байгаль орчны тухай мэдээллийн дундажминут	FM-Радиоогийн нийт нэвтрүүлэгт байгаль орчны тухай мэдээллийн хувийн хэсэг
Монголын Үндэсний Радио	120	7200	17.2	1032	111	15.9	1.5
Гэр бүлийн радио FM 104.5	168	10080	24	1440	103	14.7	1.1
Инфо FM 105.5	126	7560	18	1080	51	7.3	0.7

FM-Радиоогийн нэвтрүүлэгт байгаль орчны талаарх мэдээллийн эзлэх хувийн жинг гаргавал 0.7-1.5 буюу дунджаар 1.1 хувийг эзэлж байна. Үндэсний радио буюу шугмын радиод дээрх үзүүлэлт 1.5 хувьтай бол богино долгионы буюу FM радиод дунджаар 0.9 хувь байна.

### Байгаль орчны талаарх мэдээллийн агуулга ба хандлага

Сүүлийн жилүүдэд хэт халуун, хэт хүйтрэл, аадар бороо, ган, зуд, газар хөдлөлт, далайн салхи зэрэг байгаль дэлхийн гэнэтийн гамшигт үзэгдлүүд ихээр гарч байгаатай, мөн хүмүүсийн зүй бус үйлдэлтэй холбоотойгоор радиоогийн байгаль орчны сэдэвт нэвтрүүлэгт сөрөг хандлага /52.1 хувь/ давамгайлж байна. Үлдсэн 26.0 хувь нь эерэг сөрөг аль аль талыг агуулсан, 21.9 хувь нь эерэг мэдээлэл байлаа. Радио нэвтрүүлгийг агуулгаар нь авч үзвэл ургамал ан амьтан /19.2 хувь/, байгалийн гамшигт үзэгдлүүд /16.4 хувь/, Цаг агаарын өөрчлөлт /16.4 хувь/, байгаль хамгаалал /12.3 хувь/, Агаарын бохирдол /6.8 хувь/ зэрэгтэй холбоотой бөгөөд дийлэнхдээ сөрөг хандлагатай мэдээллүүд цацагджээ. /Дэлгэрэнгүйг Хүснэгт 3-аас харна уу/

Хүснэгт 3.

Байгаль орчны сэдэвт мэдээллийн  
агуулга, хандлага

<i>Агуулга</i>		<i>Хандлага</i>		<i>Эерэг</i>	<i>Төвийг сахисан</i>	<i>Сөрөг</i>	<i>Нийт</i>
1	Ургамал ан амьтан	2				12	14
		14.3%				85.7%	19.2%
2	Байгалийн гамшиг	3	3			6	12
		25.0%	25.0%			50.0%	16.4%
3	Цаг агаарын өөрчлөлт	2	3			7	12
		16.7%	25.0%			58.3%	16.4%
4	Бусад	4	7			1	12
		33.3%	58.3%			8.3%	16.4%
5	Байгаль хамгаалал	5	4				9
		55.6%	44.4%				12.3%
6	Агаарын бохирдол		1			4	5
			20.0%			80.0%	6.8%
7	Ашигт малтмал, орд газар					3	3
						100.0%	4.1%
8	Хог хаягдал					2	2
						100.0%	2.7%
9	Гол ус, усны бохирдол					2	2
						100.0%	2.7%
10	Улсын тусгай хамгаалалтын газар					1	1
						100.0%	1.4%
<b><i>Нийт</i></b>		<b>16</b>	<b>19</b>				<b>38</b>
		<b>21.9%</b>		<b>26.0%</b>			<b>52.1%</b>

## **Байгаль орчны талаарх мэдээллийн субъект ба хамрах хүрээ**

Радиогийн байгаль орчны сэдэвт мэдээллийн 60 орчим хувь нь олон нийтэд ханджээ. Харин улс төрчид, удирдах түвшнийхэнд хандсан 20.6 хувь, хүүхэд залуучуудад хандсан 14.7 хувь, бизнес аж ахуйн нэгж байгууллагад хандсан 4.4 хувь, тодорхой нэг хувь хүнд хандсан 2 хувьтай.

Тодорхой нэг хувь хүн, байгууллагуудад хандсан мэдээлэл нь байгаль хамгаалах чиглэлийн мэдээлэл бол улс төрчид удирдах түвшнийхэнд хандсан нь ашигт малтмал, агаарын бохирдол, хорт бодистой холбоотой, олон нийтэд хандсан мэдээллүүд нь байгаль хамгаалал, ургамал ан амьтан, хог хаягдал, гол усны бохирдол, цаг агаарын өөрчлөлттэй

холбоотой мэдээлэл байв. Байгаль орчны сэдэвт мэдээлэл нь газар зүйн хамрах хүрээний хувьд дотоодын /52.9 хувь/ бол гадаад улс орон /16.2 хувь/, дэлхий нийтийн хэмжээний /30.9 хувь/ буюу нийтдээ 47.1 хувьтай байна.

Дотоодын мэдээлэлд байгаль хамгаалал, хог хаягдал, агаарын бохирдол, ашигт малтмал, гол усны бохирдол, цаг агаарын өөрчлөлттэй холбоотой мэдээлэл байгаа бол гадаад болон дэлхий нийтийн хэмжээний мэдээлэл нь ургамал ан амьтан, байгалийн гамшигт үзэгдлүүдийн талаарх мэдээллүүд байв.

## **Байгаль орчны талаарх мэдээллийн өнцөг ба хэлбэр**

Радиогийн нэвтрүүлэг дэх байгаль орчны сэдэвт мэдээллүүд нь хэлбэрийн хувьд асуудал хөндсөн дэвшүүлсэн /36.6 хувь/ байх нь олонтой. Мөн 32.4 хувь нь сургалт, сурталчилгааны шинжтэй ч сургалтын гэхээсээ илүүтэй сурталчилгааны хэлбэртэй мэдээллүүд зонхилж байв. 26.8 хувь нь энгийн мэдээллийн хэлбэртэй, хамгийн бага хувьтай нь танин мэдэхүйн хэлбэртэй мэдээлэл бөгөөд нийт нэвтрүүлгийн 4.2-ийг эзэлдэг.

Байгаль орчны сэдэвт мэдээллүүд нь өнцгийн хувьд нэлээд тэнцвэртэй цацагдсан байна. Тухайлбал асуудлыг эдийн засгийн өнцгөөс авч үзсэн мэдээлэл 27.2 хувь, социаль буюу нийгмийн өнцгөөс нь мөн 27.2 хувь, оюун санааны өнцгөөс 25 хувь бол улс төрийн үүднээс 20.7 хувьтай байна.

Эдийн засгийн өнцгөөс хандсан мэдээллүүд нь ургамал, ан амьтан, байгалийн гамшгийн талаар байгаа бол гол усны бохирдол, агаарын бохирдол, хорт бодистой холбоотой мэдээллүүдэд улс төрийн өнцгөөс, ашигт малтмал, түүний орд газар, байгалийн гамшигт үзэгдлийн тухай социаль буюу нийгмийн өнцгөөр хандсан байх аж. Харин оюун санааны мэдээлэл нь ихэвчлэн байгаль хамгаалал, хог хаягдалтай холбоотой асуудлууд байв.

**Хүснэгт 6.**


**Байгаль орчны сэдэвт мэдээллийн хэлбэр  
FM-Радиоогоор /Хувь, давтамж/**

<i>Зорилго</i>	<i>Энгийн мэдээллийн зорилготой</i>	<i>Асуудал хөндсөн</i>	<i>Сургалт сурталчилгааны зорилготой</i>	<i>Танин мэдэхүйн зорилготой</i>	<i>Нийт</i>
<b>Радио</b>					
Монголын Үндэсний радио	10 30.3%	11 33.3%	12 36.4%	0 0.0%	33 46.5%
Гэр бүлийн радио FM 104.5	7 25.0%	9 32.1%	9 32.1%	3 10.7%	28 39.4%
Инфо FM 105.5	2 20.0%	6 60.0%	2 20.0%	0 0	10 14.1%
<b>Нийт</b>	19 26.8%	26 36.6%	23 32.4%	3 4.2%	71 100.0%

FM-Радио тус бүрийн нэвтрүүлгийг хэлбэрээр нь харьцуулбал Үндэсний радио энгийн мэдээллийн болон сургалт, сурталчилгааны хэлбэртэй байгаль орчны сэдэвт мэдээлэл давуу нэвтрүүлсэн бол Гэр бүлийн радио FM 104.5 танин мэдэхүйн чиглэлийн нэвтрүүлэг, Инфо FM 105.5 асуудал хөндсөн нэвтрүүлгийг бусдаасаа түлхүү явуулжээ.

**График 1.**

**Радиоогийн байгаль орчны сэдэвт нэвтрүүлгийн  
өнцөг /Хувиар/**



## ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

- FM-Радиоогийн байгаль орчны сэдэвт мэдээллүүд нь хамгийн багадаа нэг минут, хамгийн ихдээ 32 минутын хугацаатай бөгөөд нэг нэвтрүүлгийн үргэлжлэх хугацаа дунджаар 4 минут байв.
- Шугмын радиогоор байгаль орчны сэдэвт нэвтрүүлэг өдөрт дунджаар 15-16 минутын таван нэвтрүүлэг явдаг бол, богино долгионы радиогоор 10 минутын хоёр нэвтрүүлэг цацагддаг байна.
- FM-Радиоогийн нийт нэвтрүүлгийн 1.1 хувийг байгаль орчны талаарх мэдээлэл эзэлж байна. Үндэсний радио буюу шугмын радиод дээрх үзүүлэлт 1.5 хувь, богино долгионы буюу FM радиод дунджаар 0.9 хувьтай.
- Радио нэвтрүүлгүүд нь агуулгаараа ургамал ан амьтан /19.2 хувь/, байгалийн гамшигт үзэгдлүүд /16.4 хувь/, Цаг агаарын өөрчлөлт /16.4 хувь/, байгаль хамгаалал /12.3 хувь/, Агаарын бохирдолтой /6.8 хувь/ холбоотой нь түлхүү талаас илүү хувь нь сөрөг хандлагатай мэдээллүүд ажээ.
- Радиоогийн байгаль орчны сэдэвт мэдээллүүд нь үнэмлэхүй хэмжээгээрээ /57.4 хувь/ олон нийтэд хандсан бол улс төрчид, удирдах түвшнийхэнд хандсан 20.6 хувь, хүүхэд залуучуудад хандсан 14.7 хувь, бизнес аж ахуйн нэгж байгууллагад хандсан 4.4 хувь, тодорхой нэг хувь хүнд хандсан 2 хувьтай байна.
- Байгаль орчны сэдэвт мэдээлэл нь газар зүйн хамрах хүрээний хувьд дотоодынх голлосон /52.9 хувь/ бол гадаад улс орон /16.2 хувь/, дэлхий нийтийн хэмжээний мэдээлэл /30.9 хувь/ нийтдээ 47.1 хувьтай байна.
- Хэлбэрийн хувьд асуудал хөндсөн /36.6 хувь/ нэвтрүүлэг түлхүү аж. Сургалт, сурталчилгааны мэдээлэл 32.4 хувьтай ч үүн дундаа сургалтын гэхээсээ илүүтэйгээр сурталчилгааны хэлбэртэй мэдээллүүд нь зонхилж байлаа. Энгийн мэдээллийн хэлбэртэй нь 26.8 хувь, хамгийн бага хэмжээтэй нь танин мэдэхүйн нэвтрүүлэг бөгөөд ердөө л 4.2 хувийг эзэлж байна.
- Байгаль орчны сэдэвт мэдээллүүд нь өнцгийн хувьд тэнцвэртэй цацагджээ. Тухайлбал асуудалд эдийн засгийн өнцгөөр нь хандсан мэдээлэл 27.2 хувь, социаль буюу нийгмийн 27.2 хувь, оюун санааны 25 хувь, улс төрийн өнцгөөр хандсан нь 20.7 хувьтай байна.



## II. FM-Радиоогийн мэдээлэл дэх байгаль орчны талаарх мэдээлэл ба сэтгүүл зүйн шаардлага, хэрэгцээ

### Байгаль орчны талаарх мэдээллийн төрөл

FM-Радиоогийн байгаль орчны сэдэвт нэвтрүүлгийн төрөл түүний талаарх мэдээллийг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 7.

#### FM-Радиоогийн байгаль орчны сэдэвт нэвтрүүлгийн төрөл /Хувь, Минутаар/

Төрөл	Үзүүлэлт	Дундаж хугацаа	Хамгийн бага хугацаа	Хамгийн их хугацаа	Нийт хугацаа	Давтмал	Нийт хугацаанд эзлэх хувь	Давтмалд эзлэх хувь
Мэдээ		2,90'	1'	6'	122'	42	46,0%	61,8%
Сурвалжлага		3,90'	2'	7'	39'	10	14,7%	14,7%
Нийтлэл/Өгүүлэл		2,50'	1'	4'	5'	2	1,9%	2,9%
Ярилцлага		7,07'	1'	32'	99'	14	37,4%	20,6%
Нийт		3,90'	1'	32'	265'	68	100,0%	100,0%


Байгаль орчны сэдэвт мэдээлэл нь нэвтрүүлгийн төрлийн хувьд дунджаар гурван минутын “мэдээ” хамгийн олон буюу нийт нэвтрүүлгийн 62 орчим хувийг эзэлж байна. Үүний дараа дунджаар долоон минутын ярилцлага 20 хувийг, дунджаар дөрвөн минутын сурвалжлага 15 хувийг, дунджаар 2.5 минутын өгүүлэл, нийтлэл 2.9 хувийг эзэлж, радио сонсогчдод хүрчээ.

### Байгаль орчны талаарх мэдээллийн чанарын зарим үнэлгээ

Байгаль орчны талаарх радио нэвтрүүлгийн чанарын үнэлгээг дараах графикаас харна уу.

График 2.

#### FM-Радиоогийн байгаль орчны тухай мэдээллийн чанарын үнэлгээ /Эерэг утгаар/



Байгаль орчны сэдэвт радио мэдээллийн чанарын эерэг үзүүлэлт нь энгийн ойлгомжтой, шуурхай байдал бол дундаж үзүүлэлтүүдэд баримттай, үр өгөөжтэй, сонирхолтой, үгийн сонголт зөв, найруулга хангалттай зэргийг дурьдаж болно. Харин хангалтгүй үзүүлэлтэд мэдээллийн хэмжээ агуулга хоорондын дүйцэл, мэдээллийн

шийдлийн оновчтой байдал, техникийн тайлбаргүй нэр томъёо хэт ашигласан зэргийг дурьджээ.

Мэдээллийн чанарын эдгээр үзүүлэлтээр байгаль орчны сэдэвт радио нэвтрүүлгийн төрөл, хэлбэрийг шүүж үзвэл дараах байдалтай байна. /Хүснэгт 8, 9-с харна уу/

**Хүснэгт 8.**

**FM-Радиогийн байгаль орчны сэдэвт мэдээллийн нэвтрүүлгийн төрөл ба тэдгээрийн чанарын зарим үзүүлэлтүүд /Эерэг утгын харьцуулалтаар/**

<i>Ч-Үзүүлэлт</i>	<i>Мэдээллийн агуулга энгийн ойлгомжтой</i>	<i>Мэдээлэл хүмүүсийн анхаарлыг татахуйц сонирхолтой</i>	<i>Мэдээлэл үр өгөөжтэй</i>	<i>Мэдээллийн шийдэл оновчтой</i>	<i>Мэдээллийн хэмжээ агуулгатайгаа тохирсон</i>
<i>Б-Төрөл</i>					
Мэдээ	100.0%	78.6% <sup>1</sup>	85.7%	61.9%	54.8%
Сурвалжлага	100.0%	30.0%	60.0%	60.0%	90.0%
Нийтлэл	100.0%	100.0%	0.0%	50.0%	0.0%
Ярилцлага	85.7%	71.4%	85.7%	28.6%	50.0%
<i>Ч-Үзүүлэлт</i>	<i>Мэдээллийн найруулга хангалттай байсан</i>	<i>Мэдээлэлд хэрэглэсэн үгийн сонголт оновчтой байсан</i>	<i>Техникийн тайлбаргүй нэр томъёо ашиглаагүй</i>	<i>Тодорхой баримтид тулгуурласан</i>	<i>Цаг үедээ тохирсон шуурхай</i>
Мэдээ	71.4%	73.8%	54.8%	81.0%	88.1%
Сурвалжлага	80.0%	80.0%	10.0%	100.0%	100.0%
Нийтлэл	50.0%	50.0%	0.0%	50.0%	85.7%
Ярилцлага	50.0%	42.9%	50.0%	57.1%	86.8%

Радио мэдээ нь бусад төрлөөсөө чанарын хувьд хангалттай эерэг үнэлгээ авсан бол нийтлэл, өгүүлүүд сонсогчдод хүрэх байдлаараа хангалтгүй үзүүлэлттэй гарчээ. Радио өгүүлэл нь бусад нэвтрүүлгийн төрлөөс сонирхолтой байдгаараа давуу аж.

<sup>1</sup> Нийт мэдээний 78.6 хувь нь сонирхол татахуйц байж чаддаг бол 21.4 хувь нь сонгохол татахуйц байж чаддаггүй байна гэх мэтээр уншина. Учир нь хүснэгтэнд зөвхөн эерэг үзүүлэлтүүдийг харьцуулж тавьсан болно

**Хүснэгт 9.**

**FM-Радиоогийн байгаль орчны сэдэвт мэдээллийн хэлбэр ба чанарын зарим үзүүлэлтүүд /Эерэг утгын харьцуулалтаар/**

Радиоогийн хувьд байгаль орчны сэдэвтэй танин мэдэхүйн зорилготой нэвтрүүлгүүд илүү чанартай хийгддэг байна. Харин асуудал хөндсөн нэвтрүүлгүүд чанарын хувьд тааруу үнэлгээтэй гарсан байна. Харин асуудал хөндсөн нэвтрүүлэг нь баримтад тулгуурласан, сонирхолтой байж чаддаг байна.

**Байгаль орчны талаарх мэдээллийн эх сурвалж ба мэдээллийн тэнцвэртэй байдал**


Байгаль орчны сэдэвт радио нэвтрүүлгийг хүн ба байгаль хоорондын шүтэлцээ холбооны талаас авч үзвэл дийлэнх нь сонин, телевизийн нэвтрүүлгийн нэгэн адил байгалиас хүмүүс хүргэсэн сөрөг үр дагаврын тухай

мэдээлэл 44.1 хувиар давамгайлжээ. Удаах байранд байгаль орчин нь хүний амьдралд хүргэж байгаа ач тусын талаарх эерэг мэдээлэл 23.5 хувьтай, хүний байгаль орчинтой холбогдох эерэг үйл ажиллагааны талаарх мэдээлэл 17.6 хувь, мөн хүнээс байгаль орчинд хүргэж байгаа сөрөг үр дагаврын тухай мэдээлэл 14.7 хувьтай байна.

<i>Б-Төр</i>
Энгийн мэдээ
Асуудал хөндсөн
Сургалт, суртал зорилготой
Танин мэдэхүй
<i>Б-Төр</i>
Энгийн мэдээ
Асуудал хөндсөн
Сургалт, суртал зорилготой
Танин мэдэхүй

**График 3.**

**Байгаль орчны сэдэвт радио нэвтрүүлгийн хүн ба байгаль дэлхийн шүтэлцээ холбооны талаарх мэдээллийн тэнцвэртэй байдал /Хувиар/**



Эх сурвалж ашиглалтын хувьд олонх нь /69.1 хувь/ ил буюу эх сурвалж ашиглалт тодорхой бол далд 10.3 хувь, далдын далд 17.9 хувь, эх сурвалж тодорхойгүй хэсэг нь 2.9 хувьтай байлаа.

## ХЭСГИЙН ДУГНЭЛТ

- Байгаль орчны сэдэвт мэдээллийн 61.8 хувь нь зөвхөн мэдээгээр цацагдсан бөгөөд нэг мэдээний үргэлжлэх дундаж хугацаа 2-3 минут байв. Үүний дараа ярилцлага /20.6 хувь/, сурвалжлага /14.7 хувь/, өгүүлэл нийтлэл /2.9 хувь/ цацагджээ.

- Радиогийн байгаль орчны тухай мэдээллийн чанарын эерэг үзүүлэлтүүдэд энгийн ойлгомжтой байдал, шуурхай байдал зэргийг багтааж болно. Харин мэдээллийн хэмжээ агуулга хоорондын дүйцэл, мэдээллийн шийдлийн оновчит тал, техникийн тайлбаргүй нэр томъёо ашигласан эсэх зэрэг үзүүлэлтүүд хангалтгүй үнэлгээ авчээ.

- Мэдээ нь бусад төрлөөсөө чанарын хувьд хангалттай үнэлгээ авсан бол нийтлэл /өгүүллийн/ хангалтгүй үзүүлэлттэй байна. Гэхдээ нийтлэлийн хувьд бусад төрлөөсөө давуу үзүүлэлт нь илүү сонирхолтой байж чаддаг байна.

- Мөн хэлбэрээрээ танин мэдэхүйн нэвтрүүлгүүд илүү чанартай хийгддэг бол асуудал хөндсөн нэвтрүүлгүүд тааруу үнэлгээтэй аж. Гэхдээ асуудал хөндсөн нэвтрүүлэг нь илүү баримтжуулалт сайтай байлаг хэмээн ойлгож болно.

- Радиогийн байгаль орчны сэдэвт мэдээллийг хүн ба байгаль хоорондын шүтэлцээ холбооны талаас нь авч үзвэл дийлэнх мэдээлэл нь байгалиас хүмүүст хүргэсэн сөрөг үр дагаврын тухай мэдээлэл зонхилж байна. Үүний дараа байгаль орчин нь хүний амьдралд хүргэж байгаа ач тусын талаарх эерэг мэдээлэл, хүний байгаль орчинтой холбогдох эерэг үйл ажиллагааны талаарх мэдээлэл, мөн хүнээс байгаль орчинд хүргэж байгаа сөрөг үр дагаврын тухай мэдээлэл орж байна.

Эх сурвалж ашиглалтын хувьд үнэмлэхүй олонх нь /69.1 хувь/ ил буюу эх сурвалж тодорхой байгаа бол далд 10.3 хувь, далдын далд 17.9 хувь, эх сурвалж тодорхойгүй хэсэг нь 2.9 хувьтай байв.

### Шинжилгээний категориуд

Асуудалд аль субъект рүү хандсан:

/Тухайн асуудлыг хэнд хүргэхийг зорьсон тухай./

1. Тодорхой нэг хувь хүнд хандсан
2. Хүүхэд залуучуудад хандсан
3. Улс төрчид, нийгмийн удирдах түвшнийхэнд хандсан
4. Бизнес, аж ахуйн нэгж, хувийн хэвшлийнхэнд хандсан
5. Олон нийтэд хандсан

Байгаль орчны талаарх мэдээллийн хамрах хүрээ, маштаб

1. Нутаг орны чанартай /Дотоодын хот, аймаг, сум, дүүрэг гм/
2. Бүс нутгийн чанартай /Додоод-Төвийн, зүүн гэх мэт/
3. Улсын чанартай /Дотоод-Нийт үндэсний шинж чанартай/
4. Гадаадын тодорхой нэг улсын чанартай /Америк, Хятад гм/
5. Дэлхий нийтийн чанартай

Сэдвийн агуулга:

1. Байгаль хамгаалал
2. Ой, ойн хомсдол
3. Хог хаягдал
4. Агаарын бохирдол
5. Хөрсний бохирдол
6. Ургамал ан амьтан
7. Улсын тусгай хамгаалалттай газар /Дархан цаазат газар, цогц газар гм/
8. Ашигт малтмал
9. Байгалийн гамшиг
10. Хорт бодис
11. Озоны давхарга
12. Цөлжилт, хөрсний илэгдэл
13. Усны бохирдол
14. Цаг аргаарын өөрчлөлттэй холбоотой мэдээлэл
15. Бусад

Мэдээллийн хандлага

1. Эерэг /100000 мод үрслүүлж байна
2. Төвийг сахисан /Эерэг болон сөрөг аль алиныг нь агуулсан/
3. Сөрөг /Тужийн нарс дуусч байна

Мэдээллийн өнцөг:

/Тухайн асуудалд аль өнцгөөс нь хандаж байгааг тодруулах. Өөрөөр хэлбэл байгаль орчны эрх зүйн, эдийн засгийн үр өгөөжийн асуудал хөндсөн гэх мэт/

1. Эдийн засаг
2. Улс төр
3. Нийгмийн /Эрүүл мэнд, боловсрол, хууль эрх зүй/
4. Оюун санаа /Байгаль хамгаалах ёс зүй, ухамсар сэтгэхүйн нөлөө

Сонины мэдээллийн чанарыг хэмжих зарим үзүүлэлтүүд:

1. Мэдээллийн агуулга энгийн ойлгомжтой байсан
1. Мэдээлэл хүмүүсийн анхаарлыг татахуйц сонирхолтой байсан
2. Мэдээлэл үр өгөөжтэй байсан
3. Мэдээллийн шийдэл оновчтой байсан
4. Мэдээллийн хэмжээ агуулгатайгаа тохирсон
5. Мэдээллийн найруулга хангалттай байсан
6. Мэдээлэлд хэрэглсэн үгийн сонголт оновчтой байсан
7. Техникийн тайлбаргүй нэр томъёо ашиглаагүй
8. Тодорхой баримтад тулгуурласан
9. Цаг үедээ тохирсон шуурхай

### Сонины мэдээллийн хэлбэр

1.Энгийн мэдээллийн хэлбэртэй /Газар хөдөлжээ гм/

2.Асуудал хөндсөн /Аливаа тулгамдсан асуудлын шийдлийг гаргахыг зорьсон/

3.Сургалт, суратлчилгаа, сэрэмжийн хэлбэртэй / Газрыг хэрхэн зөв зүйтэй ашиглах вэ, байгальтай яаж харьцвал зүйтэй, ил гал бүү хая, хогоо хамаагүй газар хаяж болохгүй гм/

4.Танин мэдэхүйн хэлбэртэй /Амьтны ертөнц, байгалийн үзэсгэлэнт газар орон гм/

Хүн байгалийн шүтэлцээ, холбооны талаарх мэдээллийн тэнцвэртэй байдал

1.Байгаль орчин нь хүний амьдралд хүргэж байгаа ач тусын талаарх эерэг мэдээлэл /Ургац, рашаан, амралд сувьлагаа болж байгаа талаар

2. Хүний байгаль орчинтой холбогдох үйл ажиллагааны талаарх эерэг мэдээлэл /Мод бут тарьсан, хог цэвэрлэв гм

3. Байгалиас хүмүүст хүргэсэн сөрөг үр дагаврын тухай мэдээлэл /Байгалийн гамшиг, үер ус, хэт дулаарал

4. Хүнээс байгаль орчинд хүргэж байгаа сөрөг үр дагаврын талаарх мэдээлэл /Хог, утаа, нөхөн сэргээлтгүй газар гм

### Мэдээллийн эх сурвалж тодорхой эсэх

1.Ил /Эх сурвалжийн нэрийг дурьдах баталгаажуулах/

2.Далд /Эх сурвалжаа ерөнхийд нь тодруулж нэргүй иш татна. Жнь:


Засгийн газрын нэг томоохон албан тушаалтны хэлснээр гм/

3.Далдын далд /Сэтгүүлч тухайн мэдээллийг нэвтрүүлэгт ашигласан боловч ямар эх сурвалжаас авснаа хэлэхгүй, тодорхойгүй байх/

4.Эх сурвалж тодорхойгүй /Эх сурвалжаас авсан эсэх нь тодорхойгүй байх/

### Мэдээллийн төрөл

1. Мэдээ
2. Сурвалжлага
3. Нийтлэл / өгүүлэл
5. Ярилцлага
6. Захидал санал



# БАЙГАЛЬ ОРЧНЫ СЭДЭВТ ОЛОН НИЙТИЙН САНАЛ БОДЛЫН СУДАЛГАА

# 5.

"Байгаль орчны талаарх иргэдийн мэргэлийг хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар сайжруулах нь"

61



## “СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ”

### Түүврийн бүтэц ба хэмжээ

- Байршлаар

	<i>Давтимж</i>	<i>Хувь</i>
Сонгино-Хайрхан	80	16,0
Баянзүрх	90	18,0
Баянгол	80	16,0
Чингэлтэй	60	12,0
Сүхбаатар	50	10,0
Хан-Уул	40	8,0
Налайх	20	4,0
Багануур	20	4,0
Дархан хот	40	8,0
Зуун мод хот	20	4,0
Нийт	500	100,0

- Нас, хүйсээр

		<i>Хүйс</i>		<i>Нийт</i>
		<i>Эрэгтэй</i>	<i>Эмэгтэй</i>	
<i>Насны бүлэг</i>	<b>+14</b>	18	15	33
		54,5%	45,5%	100,0%
		6,9%	6,4%	6,7%
	<b>15-19</b>	36	34	70
		51,4%	48,6%	100,0%
		13,8%	14,6%	14,2%
	<b>20-24</b>	48	40	88
		54,5%	45,5%	100,0%
		18,5%	17,2%	17,8%
	<b>25-29</b>	34	34	68
		50,0%	50,0%	100,0%
		13,1%	14,6%	13,8%
	<b>30-34</b>	18	16	34
		52,9%	47,1%	100,0%
		6,9%	6,9%	6,9%
	<b>35-39</b>	34	24	58
		58,6%	41,4%	100,0%
		13,1%	10,3%	11,8%
	<b>40-44</b>	15	18	33
		45,5%	54,5%	100,0%
		5,8%	7,7%	6,7%
	<b>45-49</b>	18	16	34
		52,9%	47,1%	100,0%
		6,9%	6,9%	6,9%
	<b>50+</b>	39	36	75
		52,0%	48,0%	100,0%
		15,0%	15,5%	15,2%
	<b><i>Нийт</i></b>		260	233
		52,7%	47,3%	100,0%
		100,0%	100,0%	100,0%

- **Ажил эрхлэлтээр**

	<i>Давтамж</i>	<i>Хувь</i>
Дунд сургуулийн сурагч	73	14,6
Оюутан	93	18,6
Төрийн Бус Байгууллагад	37	7,4
Төсвийн байгууллагад	68	13,6
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	69	13,8
Хувийн байгууллагад	68	13,6
Тэтгэвэрт	42	8,4
Ажилгүй	30	6,0
Малчин	1	,2
Бусад	1	,2
Хариулаагүй	18	3,6
<b><i>Нийт</i></b>	<b>500</b>	<b>100,0</b>

- **Боловсролоор**

	<i>Давтамж</i>	<i>Хувь</i>
Бага	33	6,6
Бүрэн бус дунд	64	12,8
Бүрэн дунд	146	29,2
Тусгай дунд	64	12,8
Дээд /Баклавр, магистер/	166	33,2
Эрдмийн зэрэгтэй /Доктор, профессор	5	1,0
Боловсролгүй	1	,2
Хариулаагүй	21	4,2
<b><i>Нийт</i></b>	<b>500</b>	<b>100,0</b>


## I.Олон нийтийн байгаль орчны талаарх мэдлэг, мэдээллийн тухайд

### Байгаль орчныг хамгаалах шаардлага хэрэгцээний тухай мэдлэг

Байгаль орчныг хамгаалах шаардлага хэрэгцээний талаарх олон нийтийн мэдлэгийг дараах графикаар дүрслэв.

График 1.

#### Таны байгаль хамгаалах шаардлага хэрэгцээний талаар мэдлэг хэр вэ?



Судалгаанд оролцогчдын дөнгөж 26.2 хувь нь энэ талаар сайн мэдлэгтэй байгаа бол үлдсэн 73.8 хувь нь бага буюу огт мэдлэггүй ажээ.

Байгал орчны талаарх мэдлэгийн түвшин нь тухайн иргэний нас, боловсрол болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэр ашигладагтай /ялангуяа сонин ашиглалт/ шууд хамааралтай байна. Өөрөөр хэлбэл хүний нас дээшилж илүү их амьдралын туршлага суухын хэрээр, түүнчлэн боловсролын түвшин дээшлэхийн хэрээр, мөн сонин уншдаг болон тогтмол уншдаг хэсэг нь огт уншдаггүй болон бага ашигладагаасаа байгаль орчноо хамгаалах шаардлага хэрэгцээний тухай илүү мэдлэгтэй байдаг нь судалгаагаар тогтоогдлоо. Жишээ болгож боловсролын түвшин болон байгаль хамгаалах шаардлага хэрэгцээний талаарх мэдлэгийн түвшингээр солбицуулсан бүлэглэлт хийж үзүүлэв.

Хүснэгт 2.

**Байгаль орчны талаарх мэдлэгийн түвшин  
боловсролоор /Хувиар/**

		<i>БО-ы талаарх мэдлэгийн түвшин</i>			<i>Нийт</i>
		<i>Сайн мэднэ</i>	<i>Бага зэрэг мэднэ</i>	<i>Мэдэхгүй</i>	
Боловсролын түвшин	Боловсролгүй			1	1
				100,0%	100,0%
	Бага	2	12	18	33
		6,1%	36,4%	54,5%	100,0%
	Бүрэн бус дунд	11	37	14	64
		17,2%	57,8%	21,9%	100,0%
	Бүрэн дунд	36	88	21	146
		24,7%	60,3%	14,4%	100,0%
	Тусгай дунд	14	43	5	64
		21,9%	67,2%	7,8%	100,0%
Дээд /бакалавр, магистр/	61	92	11	166	
	36,7%	55,4%	6,6%	100,0%	
Эрдмийн зэрэгтэй /Доктор, профессор/	4	1		5	
	80,0%	20,0%		100,0%	
Нийт		131	278	75	500
		26,2%	55,6%	15,0%	100,0%

**Байгаль орчноо хамгаалах талаар  
иргэдийн санал бодол**

Иргэдийн олонх буюу 48.4 хувь нь “ Байгаль орчноо хамгаалахын тулд юу хийх хэрэгтэй гэж бодож байна? “ гэсэн асуултад байгаль хамгаалах шаардлагын талаар иргэдийн мэдлэг ухамсарыг дээшлүүлэх хэмээн хариулсан байна. Энэхүү хариулт нь нийт иргэдэд байгаль орчноо хайрлах, хамгаалах, мөн түүнчлэн түүнийг хэрхэн зүй зохистойгоор ашиглах тал дээр мэдлэг дутуу, шаардлагатай байгааг илэрхийлнэ. Энэ мэтчилэн бусад хариултуудыг хувь, давтамжийн буурах дарааллаар байрлуулав.

**“Байгаль орчноо хамгаалахын тулд юу хийх хэрэгтэй гэж бодож байна?”**


		<i>Давтамж</i>	<i>Хувь</i>
1.	БО-г хамгаалах шаардлагын талаар иргэдийн мэдлэг ухамсрыг дээшлүүлэх	242	48,4
2.	Гэр хорооллын утааг багасгахад байгальд хор нөлөө багатай түлш хэрэглэх	233	46,6
3.	Модыг их хэмжээгээр тарих	216	43,2
4.	Машин техникийн чанарыг сайжруулах, утааг багасгах	209	41,8
5.	Гол усаа хамгаалах	190	38,0
6.	Ногоон бүсэд газар олгохгүй байгалийг унаган төрхөөр нь хадгалах	162	32,4
7.	Агаарын бохирдлыг багасгах	159	31,8
8.	Бусад	16	3,2

**Байгаль орчинд тулгамдаж буй асуудал, олон нийтийн үнэлэмжээр**

Өнөөгийн байдлаар байгаль орчинд нэн тэргүүнд тулгамдаад буй асуудлуудыг дараах графикаас харна уу.

**График 3.**

**Байгаль орчинд тулгамдаж буй асуудлууд, олон нийтийн үнэлэмжээр**



Иргэдийн асуудалд хэрхэн хандсаныг ажиглавал юун түрүүнд өөрсдөд нь хамгийн ойр хамааралтай, эргээд нэлээд хор уршигтайгаар шууд нөлөөлж буй байгаль орчны тулгамдсан асуудлуудыг тэмдэглэсэн байна. Тухайлбал Улаанбаатар хотын агаарын бохирдол, ундны усны асуудал зэргийг нэн тэргүүнд дурьдаад, дэлхий нийтийн цаг агаарын дулаарал, цөлжилт зэрэг нэлээд глобал хэмжээний асуудлуудыг удаа нь хөнджээ.


## II. Олон нийтэд байгаль орчны тухай мэдлэг, мэдээлэл төлөвшихөд хэвлэл, мэдээллийн хэрэгслийн оролцоо

Олон нийт байгаль орчны тухай мэдлэг, мэдээллээ ямар эх сурвалжаас авдаг вэ?

Олон нийтийн байгаль орчныг хамгаалах шаардлага хэрэгцээний талаарх мэдлэг, мэдээллийг түүнчлэн тэдний ямар мэдээллийн эх сурвалж илүү ашигладгийг судлан тогтоох нь судалгааны нэг зорилго билээ. Мөн өнөөгийн нөхцөлд иргэдэд байгаль орчин түүнтэй харьцах, байгаль орчны талаарх хүний зохистой үйл ажиллагааны талаар ойлголт мэдлэг төлөвшихөд хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэр чухал оролцоотойг энэхүү судалгаагаар нээн илрүүлэх боломжтой юм.

График 5.

**Иргэд байгаль орчныг хамгаалах шаардлага хэрэгцээний тухай мэдлэгийг ямар эх сурвалжаас авдаг вэ?**



Судалгаанаас үзвэл байгаль орчныг хамгаалах шаардлага хэрэгцээний талаар тодорхой мэдлэгтэй байгаа иргэдийн үнэмлэхүй олонх буюу 74.8 хувь нь телевизээс, 38.6 хувь нь сониноос байгаль орчныг хамгаалах шаардлага хэрэгцээний талаарх мэдлэг, мэдээллээ олж авдаг гэжээ. Энэхүү үзүүлэлт нь иргэдэд дээрх мэдлэг, мэдээллийг түгээхэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл тэр дундаа телевиз, сонины үүрэг, ач холбогдол өндөр байгааг харуулж байна.

Мөн ямар эх сурвалж нь хүмүүст мэдээллийг, мэдлэг болтол нь хүргэж чадаж байгааг харьцуулан илэрхийлж болох юм.

Харьцуулалтаар мөн л телевиз, сонин хоёрын үүрэг өндөр байгааг харж болно. Тухайлбал байгаль орчныг хамгаалах шаардлага хэрэгцээний талаар сайн мэдлэгтэй хэмээн хариулсан хүмүүсийн 71 хувь, бага мэдлэгтэй хэмээн хариулсан

хүмүүсийн 76.6 хувь нь телевизээс мэдээллээ авсан байгаа бол мөн сайн мэдлэгтэй гэж хариулсан хүмүүсийн 47.3 хувь, бага мэдлэгтэй хэмээн хариулсан хүмүүсийн 34.5 хувь нь сониноос авчээ. Дэлгэрэнгүйг дараах мэдээллээс харна уу.

		<i>Мэдлэгийн түвшин</i>		
		<i>Сайн мэднэ</i>	<i>Бага зэрэг мэднэ</i>	
Мэдээллийн эх сурвалж	1.	Телевиз	71,0	76,6
	2.	Сонин	47,3	34,5
	3.	Гэр бүл	27,5	20,9
	4.	Найз нөхдөөс	18,3	23,7
	5.	Зурагт хуудас	18,3	12,9
	6.	Сэтгүүл	13,7	7,9
	7.	Интернэт	13,7	7,2
	8.	FM-Радио	13,0	13,3
	9.	Бусад	7,6	7,9


Дээрх хүснэгтэн мэдээллээс үзвэл сайн мэднэ хэмээн хариулсан хүмүүсийн 71.0 хувь нь телевизээс байгаль хамгаалах тухай мэдээлэл авсан байна. Мөн 47.3 хувь нь сонингоос авсан байх юм. /Гэх мэтчилэн уншина/

### **Байгаль орчныг хамгаалах иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн ач холбогдол**

Байгаль орчныг хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд юун түрүүнд хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар иргэдийн сэтгэхүйд нөлөөлөх хэрэгтэй гэж олон нийт үзэж байна. Энэ тухай дараах графикаас дэлгэрүүлж харна уу.

**График 6.**

**Байгаль орчныг хамгаалах иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд юу хийх хэрэгтэй гэж бодож байна вэ?**



## ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

· Нийт массын хувьд байгаль орчноо хамгаалах шаардлага хэрэгцээний тухай мэдлэг тааруухан хэмээн үзэж болно. Тэдний дөнгөж 26.2 хувь нь л энэ талаар сайн мэдлэгтэй ажээ.

· Тэдний байгаль орчныг хамгаалах шаардлага хэрэгцээний талаарх мэдлэгийн түвшин нь нас, боловсрол, хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэр ашигладагтай нь шууд хамааралтайгаар өсч байгаа юм.

· Байгаль орчны хувьд нэлээд тулгамдсан шинжтэй асуудлуудад хот орчмын агаарын бохирдол болон ундны усны асуудлууд орох бөгөөд иргэдэд мөн эдгээрийг буюу нэн түрүүнд агаарын бохирдлыг хэрхэн бууруулах талаарх мэдлэг мэдээлэл хэрэгцээтэй байна.

· Түүнчлэн иргэд байгаль орчныг хамгаалах шаардлагын талаарх мэдлэг ухамсрыг дээшлүүлэх нь нэн түрүүний асуудал хэмээн үзэж байна.

· Судалгааны дүнгээр олон нийтэд байгаль орчны тухай мэдлэг, мэдээллийг хүргэхэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл тэр дундаа телевиз, сонин зэрэг нь голлох ач холбогдолтой байна. Ямар нэг хэмжээгээр энэ талаар мэдээлэлтэй байгаа иргэдийн үнэмлэхүй олонх буюу 74.8 хувь нь телевизээс, 38.6 хувь нь сониноос мэдээллээ авсан байна.

· Мөн байгаль орчноо хамгаалах иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чухал алхам нь нэн түрүүнд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдийн ухамсарт нөлөөлөх явдал гэж олон нийт үзэж байна.

· Энэхүү төслийн хүрээнд хэрэгжүүлэх эхний ажлуудад хот, суурингын агаарын бохирдол, ундны буюу цэвэр усны сэдэвт асуудлууд байж болох юм. /Мөн иргэдийн ахуй амьдралд нь хэрэгцээтэй байж болох тухайлбал тариа, ногоо тариалж түүнийхээ үр шимийг хэрхэн хүртэх тухай гэх мэт/

· Түүнчлэн иргэдийн байгаль орчны тухай мэдлэг дээшлэхийн хэрээр асуудалд зүй зохистой хандах нь эрс нэмэгдэнэ гэвэл өрөөсгөл. Өөрөөр хэлбэл, мэдлэгтэй байна гэдэг түүнийгээ амьдрал дээр зохистойгоор хэрэгжүүлэхийн баталгаа болж хараахан чадахгүйг санах хэрэгтэй. Хүмүүсийн хэвшил болчихсон ухамсар сэтгэхүйг өөрчлөнө гэдэг нь нэлээд урт хугацаанд хэрэгжих зүйл тул энэхүү төслийн үр нөлөө нь дангаараа бус бусад олон цогц арга хэмжээтэй уялдах учиртай.

· Тухайлбал хогны асуудлыг хэрхэн шийдэх тал дээр олон туршлага байдаг. Тухайлбал Ази тивдээ хөгжлөөрөө нэлээд өндөрт ордог Сингапур улс хууль эрх зүйн үүднээс авч үзээд гудамжинд хог хаясан гадаад, дотоодын хамаагүй ямар ч иргэнийг 100 болон түүнээс дээш доллароор торгодог /Мэдээж хэрэг бусад арга хэмжээтэй уялдсан байж таарна/ болсон нь нэлээд үр дүнтэй алхам болсон бол өөр нэг улсын жишээгээр хүмүүсийн хогны талаарх сэтгэхүйг нь өөрчлөх бус ерөөсөө л хүмүүст байдаг ашигч, овжин зальхай чанарт нь нийцсэн арга хэмжээ болох хог худалдаж авах арга хэмжээг нэвтрүүлсэн нь мөн ихээхэн үр дүнд хүрсэн гэх мэт. /Мэдээж хэрэг хог дахин боловсруулах үйлдвэр барих гэх мэт бусад арга хэмжээтэй уялдсан байж таарна/



## ХАВСРАЛТ

### Олон нийтийн санал асуулгын хуудас

#### 1. Таны санааг ихээр зовоодог зүйлийг нэрлэнэ үү?

1	Улаанбаатар хотын агаарын бохирдол	1
2	Цэвэр усны нөөц багасч буй байдал	1
3	Ундны усны бохирдол	1
4	Дэлхийн цаг агаарын дулаарал	1
5	Хотын ногоон бүсийг хяналтгүй эзэмшүүлэх	1
6	Цөлжилт	1
7	Бусад	1

#### 2. Таны байгаль орчныг хамгаалах шаардлага хэрэгцээний талаар мэдлэг хэр вэ?

	Сайн мэднэ	1
1	Сонин	1
	Бага зэрэг мэднэ	1
2	FM-Радио	1
	Мэдэхгүй	1
3	Сэтгүүл	1
4	Найз нөхдөөсөө	1
5	Телевиз	1
6	Гэр бүлийнхнээс	1
7	Интернет	1
8	Ямар нэг зурагт хуудас танилцуулгаас	1
9	Бусад	1

#### 3. Энэ тухай мэдлэгийг ямар гэрээ сурвалжаас авдаг вэ?

4	Найз нөхдөөсөө	1
5	Телевиз	1
6	Гэр бүлийнхнээс	1
7	Интернет	1
8	Ямар нэг зурагт хуудас танилцуулгаас	1
9	Бусад	1

**4. Байгаль орчноо хамгаалах талаар ямар төрлийн мэдээлэл чухал хэрэгцээтэй байна вэ?**

1	Нутаг орноо ойжуулах	1
2	Ховордсон ан амьтныг өсгөж үржүүлэх	1
3	Агаарын бохирдлыг багасгах	1
4	Дэлхийн дулааралтай тэмцэх	1
5	Ашигласан газрыг нөхөн сэргээх	1
6	Усыг цэвэршүүлэх	1
7	Цөлжилтийг багасгах	1
8	Бусад	

**5. Байгаль орчноо хамгаалахын тулд юу хийх хэрэгтэй гэж бодож байна?**

1	Ногоон бүсэд газар олгохгүй байгалийг унаган төрхөөр нь хадгалах	1
2	Байгаль орчныг хамгаалах шаардлагын талаар иргэдийн мэдлэг ухамсрыг дээшлүүлэх	1
3	Гол усаа хамгаалах	1
4	Машин техникийн чанарыг сайжруулах, утааг багасгах	1
5	Гэр хорооллын утааг багасгах байгальд хор нөлөө багатай түлш хэрэглэх	1
6	Модыг их хэмжээгээр тарих	1
7	Агаарын бохирдлыг багасгах	1
8	Бусад . . .	

**6. Байгаль орчноо хамгаалах иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд юу хийх хэрэгтэй гэж бодож байна?**

1	Дээд удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлэх	1
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдийн ухамсрыг дээшлүүлэх	1
3	Идэвхтэй ажиллаж буй иргэдийг урамшуулах	1
4	Янз бүрийн компанид ажил байнга зохиох	1
5	Олныг хамарсан сургалт семинар тогтмол зохиох	1
6	Бусад	1

*Жич: Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглалтын талаар дэлгэрэнгүй асуултууд орсон болно.*

## **“Байгаль орчны талаарх иргэдийн мэдлэгийг хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар сайжруулах нь ” ТӨСЛИЙН НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

Хэвлэл мэдээллийн агуулгын судалгааны тухайд:

- Байгаль орчны сэдэвт мэдээллийн тоон хэмжээ нь улирлын чанартайгаар өөрчлөгдөөд байдаггүй. Тухайлбал, өдөр тутмын сонинд нийтлэгдсэн байгаль орчны талаарх мэдээлэл аль ч улиралд тогтмол хэмжээгээр гарч байв.

- Сонины нийт мэдээллийн 1.7 хувь нь байгаль орчны асуудалтай холбоотой байсан бол энэ нь телевизэд 1.6 хувь, радиод 1.1 хувьтай байлаа.

- Байгаль орчны тухай мэдээллийн дийлэнх хувь нь сонины эхний хагас нүүрүүдэд богино хэмжээний мэдээгээр байрласан бол, телевизийн мэдээллийн 80 гаруй хувь нь мөн 1-2 минутын мэдээнүүд байдаг. Эдгээр мэдээлэл нь ихэвчлэн байгалийн гамшигт үзэгдлийн талаарх сөрөг агуулгатай, сенсаацитай мэдээллүүд байдаг аж.

- Сонин, радио, телевизийн байгаль орчны талаарх мэдээлэлд ажиглагдсан нийтлэг нэг зүйл нь мэдээллийн зорилтот бүлэг тодорхой бус буюу хэнд, нийгмийн аль бүлэгт хандаж нийтэлж, нэвтрүүлж байгаа нь тодорхойгүй дийлэнхдээ олон нийтэд хандсан байна. Тухайлбал, сонины мэдээллийн 84.2 хувь, телевизийн 86.5 хувь, радиогийн 57.4 хувь нь олон нийтэд хандаж нэвтрүүлгээ цацжээ.

- Байгаль орчны талаарх мэдээллийг газар зүйн хамрах хүрээгээр тодруулахад сонин болон радион мэдээллийн талаас илүү хувь нь дотоодын

чанартай мэдээлэл байсан бол телевизэд эсрэгээрээ гадаадын аль нэг улсын мэдээлэл давамгайлж байлаа.

- Агуулгын талаасаа үер ус, зуд турхан, ган гачиг, далайн хар салхи, галт уул дэлбэрэлт, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн талаарх мэдээлэл аль ч мэдээллийн хэрэгсэлд түгээмэл буюу 17-30 хувьтай байна. Удаах байруудад ургамал, ан амьтан, зэрлэг ан амьтан, ашигт малтмал, түүний орд газар, цаг агаарын өөрчлөлт, байгаль хамгааллын асуудлууд орж байв. Улаанбаатар хотын хувьд нэлээд хүнд асуудалд тооцогдох агаарын бохирдлын талаар радиод илүү хөндсөн бол ой мод, модны хомсдлын талаар телевизэд илүү хөндсөн байх жишээтэй.

- Байгаль орчны талаарх мэдээллийн дийлэнх хэсэг нь байгалийн гамшигт үзэгдлийн талаар бөгөөд үүнээс улбаалан байгаль дэлхийгээс хүнд үзүүлж буй хор хөнөөлийн талаарх сөрөг талын мэдээлэл аль ч мэдээллийн хэрэгсэлд илт давуу болох нь судалгаанаас илэрхий байна. Эерэг болон төвийг сахисан мэдээлэл харьцангуй бага ажээ.

- Сонин, телевизийн байгаль орчны талаарх мэдээлэл нь ихэвчлэн энгийн мэдээллийн шинжтэй бөгөөд асуудал хөндсөн болон сургалт сурталчилгаа танин мэдэхүйн нийтлэл нэвтрүүлэг бага хувьтай. Энгийн иргэдэд байгаль орчны талаарх мэдлэг мэдээлэл олгох зорилготой бөгөөд тэдгээр нь хувь хүний өдөр тутмын амьдралд хэрэглэгдэх боломжийг агуулсан хэсэг нь хангалтгүй хэмжээтэй байна. Харин радиогийн нэвтрүүлгийн гуравны нэг нь асуудал хөндсөн өнгө аястай аж.

- Аль ч хэвлэл мэдээллийн хэрэгслийн байгаль орчны сэдэвт мэдээллийг бичлэгийн төрөл, хэлбэрээр нь ялгаж үзвэл хамгийн олон давтамжтай нь мэдээ байлаа. Энэ нь сонин нийт мэдээллийн 61.6 хувь, телевизийн 83.9 хувь, радиогийн 61.8 хувь нь зөвхөн мэдээ байсан байна.

- Мэдээллийг чанарын талаас нь авч үзвэл юун түрүүнд байгаль орчны сэдэвт мэдээллийн уншигч, хүмүүст хүргэх үр өгөөж болон сонирхолтой байлгах тал дээр анхаарах хэрэгтэй аж. Радиод энгийн мэдээлэл нь үр өгөөжтэй байсан бол нийтлэл өгүүллэг нь хангалтгүй үзүүлэлттэй. Сонин, телевизэд мэдээ нь хангалтгүй харин асуудал хөндсөн нийтлэл, ярилцлагууд нь харьцангуй үнэлгээ сайтай гарчээ.

- Байгаль орчны талаарх мэдээллийн эх сурвалж тодорхой буюу ил, асуудал хөндсөн өгүүлэл, нийтлэл зэрэг нь статистик тоо баримт, судалгааны материалд илүү тулгуурласан байгаа нь сайшаалтай. Гэхдээ тухайн тоо баримтаа хаанаас, ямар эх сурвалж, материалаас авсанаа бүрэн тодорхойлж, тэмдэглэх нь аль ч мэдээллийн хэрэгсэлд дутмаг байгаа нь ажиглагдаж байна.

- Мэдээллийн хэлбэр талаас нь хандвал сургалт болон танин мэдэхүйн хэлбэртэй байгаль орчны сэдэвт мэдээллүүд нь илүү сонирхолтойн дээр үр өгөөжтэй байсан ч бусад хэлбэрүүдтэй харьцуулбал давтамж, талбайн хувьд бага байв.

Олон нийтийн санал асуулгын судалгааны хувьд:

- Олон нийтийн хувьд байгаль орчноо хамгаалах шаардлага хэрэгцээний тухай мэдлэг тааруухан хэмээн үзэж болно. Тэдний 26.2 хувь нь энэ талаар сайн мэдлэгтэй бөгөөд тэдний байгаль орчныг хамгаалах шаардлага хэрэгцээний талаарх мэдлэгийн түвшин нь нас, боловсрол, хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэр ашигладагтай нь шууд хамааралтайгаар өсч байдаг.

- Байгаль орчны тулгамдсан асуудлуудад хот орчмын агаарын бохирдол болон ундны цэвэр усны асуудал орж байна. Мөн иргэдийн байгаль орчныг хэрхэн хамгаалах талаарх мэдлэг ухамсрыг дээшлүүлэх асуудал эн тэргүүнд тавигдаж байгаа нь судалгаанаас тодорхой харагдаж байна.

- Иргэдийн байгаль орчны талаарх мэдлэгийг сайжруулахад хэвлэл мэдээллийн хэрэгсэл тэр дундаа сонин, телевизийн үүрэг, ач холбогдол өндөр ажээ.



**БАЙГАЛЬ ОРЧНЫ  
ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ  
АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ  
МЭРГЭЖЛИЙН БОЛОН  
ТӨРИЙН БУС  
БАЙГУУЛЛАГУУДАД  
ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ**

**6.**

*"Байгаль орчны талаарх иргэдийн мэргэгийг хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар сайжруулах нь"*

**75**


## Хэвлэл мэдээллийн хэрэгслийн ашиглалтын тухайд

Хэвлэлийн Хүрээлэнгийн Мэдээлэл Судалгааны алба 1999 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлж буй “Монголын хэвлэл мэдээллийн мониторинг” судалгааны дүнгийн 2005 оны урьдчилсан байдлаар Монголд 157 сонин, 70 сэтгүүл, 44 радио /Үүнээс 34 нь FM радио/, 38 телевиз мөн 16 кабелийн үйлчилгээний телевиз тогтмол үйл ажиллагаа явуулдаг байна.

Түүнчлэн иргэдийн дотоодын мэдээлэл авдаг хамгийн гол эх сурвалж нь телевиз, сонин байсан бөгөөд энэ нь мөн тэдний байгаль орчны талаарх мэдлэг мэдээллээ олж авдаг гол эх сурвалжуудтай нь давхцаж байгааг дурьдах нь зүйтэй.

### Хүснэгт 1.

**Иргэдийн дотоодын болон байгаль орчны тухай мэдлэг, мэдээлэл авдаг хамгийн гол эх сурвалжууд**




Үүнээс үзвэл тус төслийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл дундаа телевиз, сонинд илүүтэйгээр түшиглэх нь харьцангуйгаар үр өгөөжтэй байж болох талтай.

Өнөөгийн байдлаар нийт мэдээлэл дунд нь байгаль орчны холбогдолтой мэдээ, мэдээллийн эзлэх хувийн жингээр телевиз 0.7-2.5 буюу дунджаар 1.6 хувьтай, сонин 1.1-3.1 буюу дунджаар 1.7 хувьтай, FM-Радио 0.7-1.5 буюу дунджаар 1.1 хувьтай /Шугамын радио 1.5 хувь, Богино долгионы радио 0.9 хувьтай/ байгаа нь зар сурталчилгаа, улс төр, эдийн засаг гм бусад мэдээллийн

төрлүүдтэй харьцуулбал нэлээд бага хэмжээ юм. Өөрөөр хэлбэл өнөөгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр цацагдаж буй мэдээллийн тэнцвэржилт хангалтгүй хэмжээнд байна. Тухайлбал энд жишээ болгож өдөр тутмын долоон сонины долоо хоногийн дугаарт нийтлэгдсэн мэдээллийн агуулгат хийсэн задлан шинжилгээний дүнг танилцуулъя.

**График 1.**

**Өдөр тутмын сонины агуулгат хийсэн задлан шинжилгээний дүн /Хувь/**



## “Байгаль орчны сэдэвт мэдээллийг хэрхэн цацах нь зүйтэй вэ?”

• Байгаль орчин, түүнтэй зүй зохистой харьцах, хандах тухай мэдлэг, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар олон нийтэд хүргэхийн дээр, энэхүү үйл ажиллагаанаас эргээд эерэг хүлээлттэй байхын тухайд юуны өмнө хоёр талаар анхаарах хэрэгтэй. **Үүнд:**

1. Мэдээллийн тоон тал

2. Мэдээллийн агуулга ба чанарын тал

Телевиз, сонин, радиогийн байгаль орчны сэдэвт мэдээллүүдийг дээрх хоёр талаас нь дараах схемээр шинжих боломжтой.

• Дээрх хоёр тал нь хоёулаа л чухал бөгөөд мэдээллийн тоон талыг нь нэмж сайжруулах тухай асуудал нь тухайн мэдээллийн хэрэгслийн менежмент, маркетинг, санхүүжилтийн асуудалтай холбоотой учраас өөрчлөлт оруулахад нэлээд бэрхшээлтэй байж болох, харин агуулга ба чанарын талыг сэтгүүлчдийн ур чадварт нөлөөлөх замаар сайжруулах боломжтой.

• Телевиз, сонин, FM-Радио зэрэг мэдээллийн хэрэгслүүдийг байгаль орчны мэдээлэл түгээхэд ашиглахдаа наад зах нь дараах зүйлүүдийг харгалзаж үзэх хэрэгтэй юм.

• Телевиз нь бусад мэдээллийн

хэрэгслүүдтэй харьцуулбал нэлээд давуу талтай. Тухайлбал хөгшин, залуу, хүүхэд аль ч насны ямарч ажил мэргэжил болоод боловсролтой хүмүүс үзэх боломжтой учраас хүртээмж сайтай. Мөн телевизийн мэдээллийг хүмүүс хараад, сонсдог учраас илүү ойлгомжтой, үр дүнтэй байж чадна. Хүмүүс ихэнхдээ алжаалаа тайлах болон мэдээлэл авах зорилгоор үздэг тул ямар ч төрлийн /Мэдээ, Боловсрол танин мэдэхүйн гм/ мэдээлэл явуулсан боломжтой. Тиймээс бусад мэдээллийн хэрэгслүүдтэй харьцуулбал хугацааны хувьд урт, боловсрол танин мэдэхүйн болон хүүхэд залуучуудын, нийгэм улс төрийн гэх мэт тусгай нэвтрүүлгүүдийг гаргах нь зүйтэй юм.

• Харин FM-ийг хүмүүс мэдээлэл авах гэхээсээ илүүтэйгээр алжаалаа тайлах зорилгоор сонсдог тул богино хугацааны мэдээнүүд голлож дийлэнхдээ хүүхэд залуучууд сонсдог учраас залхаахгүй сонирхолтой, үр өгөөжтэй танин мэдэхүйн хэлбэртэй /утсаар асуулт хариулт, таавар гэх мэт/ нэвтрүүлгүүд байх нь оновчтой.

• Шугмын радиогийн сонсогчид алжаалаа тайлахаасаа илүүтэйгээр мэдээлэл авах зорилготой учир телевизийн адил мэдээллийн ямар ч төрөл явуулсан боломжийн боловч нэг хүртэхүйгээр /сонсох/ хүлээн авдаг тул залхах магадлал ихтэйгээс бусад мэдээллийн хэрэгслүүдтэй харьцуулбал дундаж хугацаатай байвал зүгээр.

• Өдөр тутмын сонины хувьд хүмүүс алжаал тайлах гэхээсээ илүүтэйгээр мэдээлэл авах зорилгоор уншиж танилцдаг тул байгаль орчны сэдэвт мэдээллээ ямар ч бичлэгийн төрлөөр гаргаж болно.

• Судалгааны дүнгээр эдгээр мэдээллийн хэрэгслүүдээр цацагдаж байгаа мэдээллүүд нь үнэмлэхүй утгаараа олон нийтэд хандсан байгаа. Иймэрхүү ерөнхий байдалтай бус тодорхой байдлаар нарийвчилж хүүхэд залуучуудад, тариаланчдад, пүүс компаниудад, удирдах түвшнийхэнд гэх зэргээр нийгмийн бүлгүүдээр хайрцаглаж өгвөл үр дүнтэй



байх болно.

- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар иргэдийн байгаль орчны талаарх мэдлэгийг дээшлүүлэх гэдгийг энгийн утгаар нь ойлговол маркетингийн зарчимтай ижил. Тиймээс юуны өмнө тухайн мэдээллээ хүргэх зорилтот бүлгүүдээ тодорхойлох хэрэгтэй бөгөөд тэдэнд хамаарах бусад онцлог шинжүүдийг судалсан байх ёстой юм.


- Тухайлбал телевиз болон радиогийн хувьд үзэгч, сонсогчдын оргил цаг, зорилтот бүлгийн сонсдог, үздэг цаг, цаашлаад зорилтот бүлгийн үзэх, сонсох дуртай мэдээлэл, нэвтрүүлэг гэх мэтээр. Зорилтот бүлэг гэдгийг маш олон өнцгөөс нь ангилж үзэж болно. Тухайлбал насаар,

хүйсээр, мэргэжлээр, эрхэлдэг ажил хөдөлмөрөөр, сонирхолоор, үзэх сонсох дуртай нэвтрүүлгээр нь гэх мэтээр


- Эдгээр хүчин зүйлүүдийг харгалзахгүйгээр түгээсэн мэдээллийг зорилтот бүлэгтээ хүрсэн хэмээн ойлгох нь бүрхэг болно. Тухайлбал: Хэвлэлийн Хүрээлэнгээс сар тутам эрхлэн гаргадаг Хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийн судалгааны дүнгээр ТВ үзэгчдийн оргил цаг дунджаар 20.30-22.30, радио сонсогчдынх өдрийн 12.00-14.00 цаг байдаг. Байгаль орчны талаарх мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй цагийг тодруулбал ТВ 18.00-19.00 цагт, радиод өглөөний 08.00-09.00 цагт хамгийн ихээр цацагддаг аж.

### Байгаль орчны талаарх мэдээллүүд телевиз радиогоор цацагдсан хугацааны байдал

Телевиз



FM-Радио



## Байгаль орчны сэдвээр бичдэг сэтгүүлчдэд зориулсан зөвлөмж

Байгаль орчны талаарх мэдээллийн давтамж улирлын чанартайгаар өөрчлөгддөггүй, харьцангуй тогтвортой байгаа. Өөрөөр хэлбэл байгаль орчны сэдэв нь мэдээллийн хэрэгслийн нийтлэл нэвтрүүлгийн бодлогод өөрийн гэсэн байр суурийг хэдийнэ эзэлсэн гэдгийг илтгэж байна. Хэдий тийм боловч ерөнхийдөө байгаль орчны талаар мэдээ мэдээллийн эзлэх хувь харьцангуй бага, тухайлбал сонин хэвлэл дэх гэмт хэргийн талаарх мэдээллээс байгаль орчны талаарх мэдээлэл тав дахин бага байна.

Байгаль орчны сэдвээр өдөр тутмын сонинд нийтэлсэн материалын дийлэнх хувь нь байгалийн гамшигт үзэгдлүүдийн тухай сөрөг утга бүхий мэдээ байна. Гэтэл ийм төрлийн мэдээлэл нь иргэдийн ой санаанд төдийлөн үлдэж, тэр тусмаа байгаль орчныг хамгаалах шаардлага хэрэгцээ, ач холбогдлын талаар ойлголт өгч чаддаггүй бөгөөд, сонин уншигчид илүү дэлгэрэнгүй, амьдралд болон өдөр тутмын хэрэгцээнд хэрэг болохуйц танин мэдэхүйн чанартай мэдээллийг хүсэн хүлээдэг байна.

Байгаль орчны сэдэвт мэдээллийг иргэдэд илүү хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох үүднээс дараах зөвлөмжийг санал болгож байна.

- Байгаль орчны асуудлыг иргэдийн ахуй амьдрал, эрүүл мэнд, үр хүүхдэд чухам ямар үр нөлөө, ач холбогдолтойг тайлбарлан таниулсан мэдээлэл иргэдийн сонирхолыг илүү татаж, үр өгөөж нь илүү өндөр байна.

- Байгаль орчны сэдэвт дээрх төрлийн мэдээ нийтлэлийг тогтмол буланд, эсвэл тогтсон хөмсөг гарчиг, тогтмол нүүрэнд байршуулж байвал өөрийн гэсэн уншигчдын хүрээтэй болж, энэ сэдвийн хүртээмж нь илүү дээшлэх магадлалтай.

- Нийтлэл, өгүүлэл, ярилцлага зэрэг байгаль орчны сэдэвт дэлгэрэнгүй мэдээллийг чухам хэнд хандаж нийтэлж буйгаа анхнаас нь тодорхойлж, тухайн хэсэг бүлэг хүмүүсийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бичих нь илүү үр дүнтэй байх болно.

- Хэвлэл мэдээллийн хэрэглэгчид өөрийн ойр орчны талаарх мэдээллийг илүүтэй сонирхдог учир тухайн нутаг дэвсгэр, дүүрэг, аймаг хотод тулгамдаж буй байгаль орчны асуудал бөгөөд түүний үр дагаврын талаарх мэдээлэл нь уншигчдын хувьд хаа нэгтээ дэлхийн нөгөө өнцөгт үер болсон тухай мэдээллээс илүү чухал байдаг.

- Байгаль орчны талаарх мэдээ нийтлэлдээ Монголын сэтгүүлчид тоо баримт, судалгаа нэлээд ашиглаж байгаа нь сайшаалтай боловч тэдгээр нь ихэнхдээ асуудлыг илүү ойлгомжтой болгохоосоо илүү төөрөгдүүлж, буруу ташаа ойлголт төрүүлэх хандлагатай байна. Учир нь тухайн тоо баримтын цаад утга учрыг үнэн зөв ойлгож, “энгийн хэлэнд” орчуулах сэтгүүлчдийн мэдлэг чадвар дутмаг байгааг анзаарч болно. Тоо баримт ашиглахдаа утга, ухагдахууныг харьцуулж, аль болох энгийн хэлээр илэрхийлэх нь илүү оновчтой бөгөөд сонирхолтой байдгийг анхаарна уу.

- Байгаль орчны асуудлаар энгийн ойлгомжтой бичихийн тулд шинжлэх ухааны нэр томъёог орчуулалгүй эсвэл тайлбаргүй ашиглахаас зайлсхийх нь зүйтэй.



## СУДАЛГААНЫ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛСЭН:

---

### Төслийн зөвлөх

М.Мөнхмандах  
/XX-ийн гүйцэтгэх захирал/

### Төслийн зохицуулагч

Г.Гүнжидмаа  
/Мэдээлэл, судалгааны албаны дарга/

### Судалгааны мэдээлэл боловсруулж, тайлан бэлтгэсэн

Г.Цогтбаатар /Судлаач/

### Судлаачид

О.Анхбаатар  
О.Баярмаа  
Д.Энхнаран

### Судалгааны мэдээлэл бүрдүүлсэн

Гэрээт 15 судлаач

### Дизайнер

С.Лхагвасүрэн  
Б.Ням-Очир

### Хэвлэлийн Хүрээлэн Мэдээлэл Судалгааны алба

Их тойруу-116, ш.х 20/347  
Улаанбаатар, Монгол Улс

**И-мэйл:** [pressinst@pressinst.org.mn](mailto:pressinst@pressinst.org.mn)

**Web:** <http://www.pressinst.org.mn>

**Утас:** 353475

**Факс:** 350002